



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# УЛААНБААТАР ХОТЫН ГЭР ХОРООЛЛЫН ӨРХИЙН ИНТЕРНЕТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭ, СЭТГЭЛ ХАНАМЖ

**Захиалагч:** Харилцаа, холбооны зохицуулах хороо

**Гүйцэтгэгч:** Максима судалгааны төв

---

2022 он

## АГУУЛГА

График хүснэгтийн жагсаалт .....	2
Нэг. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА .....	5
1.1. Судалгааны зорилго .....	5
1.2. Судалгааны зорилт .....	5
1.3. Судалгааны хамрах хүрээ .....	5
1.3.1. Судалгааны эх олонлог, хамрах хүрээ, түүвэрлэлтийн нэгж .....	5
1.3.2. Түүврийн зохиомж, хэмжээ, хуваарилалт .....	5
1.4. Судалгааны аргазүй.....	6
1.5. Судалгааны тайлан боловсруулах аргачлал, бүрэлдэхүүн .....	7
Нэг. ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	7
1.1. Өрхийн сарын дундаж орлого, харилцаа холбооны зардал, бусад үзүүлэлт .....	7
1.2. Өрхийн интернет ашиглах боломжит төхөөрөмж, интернет холболт, хугацаа .....	10
1.3. Интернет холбогдоогүй шалтгаан, ирээдүйн төлөвлөгөө .....	12
Хоёр. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭ .....	14
2.1. Интернет хэрэглээ, давтамж, байршил болон зорилго.....	14
2.2. Гар утасны дата хэрэглээтэй холбоотой зарим үзүүлэлт .....	20
2.3. ГЭРТЭЭ интернет хэрэглэдэг эсэх тухай зарим үзүүлэлт .....	23
2.4. Интернет хэрэглэдэггүй түвшин, шалтгаан .....	24
Гурав. ӨРХИЙН ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ .....	26
3.1. Сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйл, тэдгээрийн үнэлгээ, харьцуулалт .....	26
3.2. Зарим гол нийлүүлэгч тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ, харьцуулалт .....	29
3.2.1. Юнивишн үйлчилгээ авдаг өрхүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээ.....	29
3.2.2. ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээ авдаг өрхүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	31
3.2.3. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт .....	33
Дөрөв. ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН ХАМРАГДАЛТЫН ТУХАЙ.....	39
Тав. ХҮН АМЗҮЙН МЭДЭЭЛЭЛ .....	40
ДҮГНЭЛТ.....	42

## График хүснэгтийн жагсаалт

<b>Зураг 1.</b> Судалгаанд оролцогчдын өрхийн сарын орлого.....	7
<b>Зураг 2.</b> Өрхийн сарын орлого, өрхийн интернет холболттой эсэх төрлөөр .....	7
<b>Зураг 3.</b> Өрхийн сарын дундаж орлого, тооцооллын утга, өрхийн интернет холболттой эсэх төрлөөр.....	8
<b>Зураг 4.</b> Өрхийн сарын дундаж мэдээлэл, харилцаа холбооны зардлын хэмжээ, утга, өрхийн интернет холболттой эсэх төрлөөр.....	8
<b>Зураг 5.</b> Мэдээлэл, харилцаа холбооны зардлын өрхийн орлогод эзлэх хувь.....	9
<b>Зураг 6.</b> Өрхийн сарын дундаж мэдээлэл, харилцаа холбооны зардлын бүтэц .....	9
<b>Зураг 7.</b> Судалгаанд оролцогчдын амьдардаг сууцны төрөл.....	9
<b>Зураг 8.</b> Интернет ашиглах боломжтой төхөөрөмж байгаа эсэх үнэлгээ.....	10
<b>Зураг 9.</b> Гар утастай эсэх, насны бүлгээр, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн.....	10
<b>Зураг 10.</b> Гар утастай эсэх, насны бүлгээр, утасны төрлөөр.....	11
<b>Зураг 11.</b> Өрхийн интернет хэрэглэсэн хугацаа, өрхийн интернеттэй=100% .....	11
<b>Зураг 12.</b> Өрхийн интернет үйлчилгээ авдаг байгууллага, өрхийн интернеттэй=100% .....	11
<b>Зураг 13.</b> Өрхийн интернет үйлчилгээний сарын дундаж зардал, зарим байгууллагаар .....	12
<b>Зураг 14.</b> Интернетэд холбогдоогүй шалтгаан, өрхийн интернетгүй=100% .....	13
<b>Зураг 15.</b> Өрхийн интернеттэй болох төлөвлөгөө байгаа эсэх, өрхийн интернетгүй=100% ....	13
<b>Зураг 16.</b> Шилэн кабелийн суурин интернет ашиглах боломж бүрдвэл ашиглах эсэх, (Юнивишн хэрэглэгчээс бусад бүх оролцогч=100%).....	14
<b>Зураг 17.</b> Интернет хэрэглэдэг эсэх үнэлгээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн.....	14
<b>Зураг 18.</b> Интернет хэрэглэдэг эсэх үнэлгээ, үндсэн асуулт буюу судалгаанд оролцогчдын хувьд .....	15
<b>Зураг 19.</b> Интернет хэрэглэдэг эсэх үнэлгээ, өрхийн интернеттэй эсэх үнэлгээгээр .....	15
<b>Зураг 20.</b> Судалгаанд оролцогчдын интернет ашиглах давтамж, интернет хэрэглэдэг=100% 15	
<b>Зураг 21.</b> Судалгаанд оролцогчдын интернет ашиглах давтамжийг оноонд шилжүүлсэн тооцоолол, насны бүлгээр .....	16
<b>Зураг 22.</b> Судалгаанд оролцогчдын интернет хэрэглэх байршил.....	16
<b>Зураг 23.</b> Судалгаанд оролцогчдын интернет ашиглах төрөл .....	17
<b>Зураг 24.</b> WIFI, өрхийн суурин интернетийн хэрэглээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн.....	18
<b>Зураг 25.</b> Судалгаанд оролцогчдын интернет ашиглах төхөөрөмж.....	18
<b>Зураг 26.</b> Судалгаанд оролцогчдын интернет ашиглах ТОП10 зорилго.....	18
<b>Зураг 27.</b> Гар утасны дата хэрэглээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн, бүлэг тус бүрийн нийт оролцогчийг 100% гэж тооцсон. ....	20
<b>Зураг 28.</b> Гар утасны дата хэрэглээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн, бүлэг тус бүрийн интернет хэрэглэдэг оролцогчийг 100% гэж тооцсон. ....	20
<b>Зураг 29.</b> Судалгаанд оролцогчдын гар утасны дата хэрэглэх байдал .....	20
<b>Зураг 30.</b> Судалгаанд оролцогчдын гар утасны дата хэрэглэх байдал, харьцуулалт .....	20
<b>Зураг 31.</b> Судалгаанд оролцогчдын сард ашигладаг датаны хэмжээ, дата хэрэглэдэг 100% 21	
<b>Зураг 32.</b> Судалгаанд оролцогчдын сард ашигладаг датаны хэмжээ, харьцуулалт .....	21
<b>Зураг 33.</b> Сард багадаа 10GB дата хэрэглэдэг хувь, насны бүлгээр .....	21
<b>Зураг 34.</b> Гар утасны датагаа хэрхэн шийддэг тухай.....	22
<b>Зураг 35.</b> Нэмэлт дата авахад зарцуулж буй сарын дундаж зардал .....	22
<b>Зураг 36.</b> Судалгаанд оролцогчдын гар утасны дата хэрэглэдэг байршил .....	22
<b>Зураг 37.</b> ГЭРТЭЭ интернет хэрэглэдэг төвшин .....	23
<b>Зураг 38.</b> Нийт интернет хэрэглээний хэдэн хувийг ГЭРТЭЭ хэрэглэдэг тухай үр дүн.....	23
<b>Зураг 39.</b> Судалгаанд оролцогчдын ГЭРТЭЭ интернет ашиглах зорилго .....	23
<b>Зураг 40.</b> Шилэн кабелийн интернет ашиглах боломж бүрдвэл ГЭРТЭЭ интернет ашиглах хэмжээ, хугацаа өсөх тухай төсөөлөл .....	24

<b>Зураг 41.</b> Шилэн кабелийн интернет ашиглах боломж бүрдвэл ГЭРТЭЭ интернет ашиглах хэмжээ, хугацаа өсөх тухай төсөөлөл, өрхийн интернеттэй эсэхээр .....	24
<b>Зураг 42.</b> Интернет хэрэглэдэггүй төвшин, өрхийн гишүүн бүрийн асуултын үр дүн .....	24
<b>Зураг 43.</b> Судалгаанд оролцогчдын интернет хэрэглэдэггүй түвшин .....	25
<b>Зураг 44.</b> Интернет хэрэглэдэггүй шалтгаан, ашигладаггүй бол 100% .....	25
<b>Зураг 45.</b> Өрхийн интернетийн хамгийн чухал 5 үзүүлэлт .....	26
<b>Зураг 46.</b> Өрхийн интернетийн хамгийн чухал 5 үзүүлэлт, өрхийн интернеттэй оролцогчийн хувьд .....	26
<b>Зураг 47.</b> Өрхийн интернетийн хамгийн чухал 5 үзүүлэлт, өрхийн интернетгүй оролцогчийн хувьд .....	26
<b>Зураг 48.</b> Сэтгэл ханамжийн ЭЕРЭГ үнэлгээний нийлбэрээр тэргүүлэгч 5 хүчин зүйлс (5 болон 4 хариултын нийлбэр) .....	27
<b>Зураг 49.</b> Сэтгэл ханамжийн ЭЕРЭГ үнэлгээний нийлбэрээр хамгийн бага 5 хүчин зүйлс (5 болон 4 хариултын нийлбэр) .....	27
<b>Зураг 50.</b> Сэтгэл ханамжийн СӨРӨГ үнэлгээний нийлбэрээр тэргүүлэгч 5 хүчин зүйлс (2 болон 1 хариултын нийлбэр) .....	28
<b>Зураг 51.</b> Сэтгэл ханамжийн СӨРӨГ үнэлгээний нийлбэрээр хамгийн бага 5 хүчин зүйлс (2 болон 1 хариултын нийлбэр) .....	28
<b>Зураг 52.</b> Сэтгэл ханамжийн ОНОО, тэргүүлэгч 5 хүчин зүйл, тооцоолсон утга .....	28
<b>Зураг 53.</b> Сэтгэл ханамжийн ОНОО, хамгийн бага 5 хүчин зүйл, тооцоолсон утга .....	28
<b>Зураг 54.</b> Юнивишн, ЭЕРЭГ үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс .....	30
<b>Зураг 55.</b> Юнивишн, ЭЕРЭГ үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс .....	30
<b>Зураг 56.</b> Юнивишн, СӨРӨГ үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс .....	30
<b>Зураг 57.</b> Юнивишн, СӨРӨГ үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс .....	30
<b>Зураг 58.</b> Юнивишн, сэтгэл ханамжийн оноо, хамгийн өндөр 5 хүчин зүйлс .....	30
<b>Зураг 59.</b> Юнивишн, сэтгэл ханамжийн оноо, хамгийн бага 5 хүчин зүйлс .....	30
<b>Зураг 60.</b> ГЭР ИНТЕРНЕТ, Эерэг үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс .....	32
<b>Зураг 61.</b> ГЭР ИНТЕРНЕТ, Эерэг үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс .....	32
<b>Зураг 62.</b> ГЭР ИНТЕРНЕТ, Сөрөг үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс .....	32
<b>Зураг 63.</b> ГЭР ИНТЕРНЕТ, Сөрөг үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс .....	32
<b>Зураг 64.</b> ГЭР ИНТЕРНЕТ, сэтгэл ханамжийн оноо, хамгийн өндөр 5 хүчин зүйлс .....	33
<b>Зураг 65.</b> ГЭР ИНТЕРНЕТ, сэтгэл ханамжийн оноо, хамгийн бага 5 хүчин зүйлс .....	33
<b>Зураг 66.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 01 .....	34
<b>Зураг 67.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 02 .....	34
<b>Зураг 68.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 03 .....	35
<b>Зураг 69.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 04 .....	35
<b>Зураг 70.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 05 .....	35
<b>Зураг 71.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 06 .....	36
<b>Зураг 72.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 07 .....	36
<b>Зураг 73.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 08 .....	36
<b>Зураг 74.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 09 .....	37
<b>Зураг 75.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 10 .....	37
<b>Зураг 76.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 11 .....	37
<b>Зураг 77.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 12 .....	38
<b>Зураг 78.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 13 .....	38
<b>Зураг 79.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 14 .....	38
<b>Зураг 80.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 15 .....	39
<b>Зураг 81.</b> Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 16 .....	39
<b>Зураг 82.</b> Сургуулийн насны хүүхэдтэй эсэх .....	40
<b>Зураг 83.</b> Цахим сургалтад хамрагдсан эсэх, сургуулийн насны хүүхэдтэй бол 100% .....	40
<b>Зураг 84.</b> Цахим сургалтад хамрагдсан хэлбэр, хамрагдсан бол 100% .....	40

<b>Зураг 85.</b> Цахим сургалтад хамрагдаагүй шалтгаан, хамрагдаагүй бол 100% .....	40
<b>Зураг 86.</b> Судалгаанд оролцогчдын ам бүлийн тоо .....	40
<b>Зураг 87.</b> Судалгаанд оролцогчдын насны бүлэг.....	41
<b>Зураг 88.</b> Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа .....	41
<b>Зураг 89.</b> Судалгаанд оролцогчдын боловсрол .....	41
<b>Зураг 90.</b> Судалгаанд оролцогчдын ажил эрхэлдэг эсэх.....	41
<b>Хүснэгт 1.</b> Түүврийн хуваарилалт.....	6
<b>Хүснэгт 2.</b> Өрхийн дундаж орлого тооцоход ашиглагдахад бүлгийн мэдээлэл .....	8
<b>Хүснэгт 3.</b> Судалгаанд оролцогчдын интернет ашиглах давтамж, насны бүлэг бүрийн интернет хэрэглэдэг=100%.....	15
<b>Хүснэгт 4.</b> Ажлын өдрөөр интернет хэрэглэх давтамж, байршлаар.....	17
<b>Хүснэгт 5.</b> Амралтын өдрөөр интернет хэрэглэх давтамж, байршлаар .....	17
<b>Хүснэгт 6.</b> Судалгаанд оролцогчдын интернет ашиглах зорилго .....	19
<b>Хүснэгт 7.</b> Судалгаанд оролцогчдын сард ашигладаг датаны хэмжээ, насны бүлгээр .....	22
<b>Хүснэгт 8.</b> Өрхийн интернетийн хамгийн чухал үзүүлэлтүүд .....	27
<b>Хүснэгт 9.</b> Өрхийн интернеттэй өрхүүдийн хүчин зүйлс тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ .....	29
<b>Хүснэгт 10.</b> ЮНИВИШН үйлчилгээг авдаг өрхүүдийн хүчин зүйлс тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ.....	31
<b>Хүснэгт 11.</b> ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээг авдаг өрхүүдийн хүчин зүйлс тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ.....	33
<b>Хүснэгт 12.</b> Ажил хийдэг бол .....	41
<b>Хүснэгт 13.</b> Ажил хийдэггүй бол .....	41

## Нэг. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Энэ бүлэгт судалгааны зорилго, зорилт, аргазүй болон мэдээлэл цуглуулалт, боловсруулалтын үе шатын талаар дэлгэрэнгүй тайлбарлана.

### 1.1. Судалгааны зорилго

Энэхүү судалгаа нь Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн интернет үйлчилгээний хэрэглээ (*интернет үйлчилгээний холболтын төрөл, хурд, үнэ тариф /багц/, чанар, нэг сард МХХ-ны үйлчилгээнд зарцуулсан зардал г.м*) интернетийн сүлжээнд холбогдоход гарч байгаа хүндрэл бэрхшээл, үйлчилгээний талаарх сэтгэл ханамж, өрхийн худалдан авах чадвар, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, үнэлэлт өгөх зорилготой болно.

### 1.2. Судалгааны зорилт

Судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг тавьж ажиллалаа. Үүнд:

- ❖ Улаанбаатар хотын гэр хорооллын интернет хэрэглээ, худалдан авах чадварыг тодорхойлох;
- ❖ Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн интернетэд холбогдсон байдал, сэтгэл ханамж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох;
- ❖ Улаанбаатар хотын гэр хорооллын өрхийн интернетэд холбогдоогүй шалтгаан, боломж бүрдвэл холбогдох сонирхол байгаа эсэхийг тодорхойлох;
- ❖ Интернет хэрэглээг байршил, интернетэд холбогдох төрлөөр гэх мэтчилэн нарийвчлан тодорхойлох;

### 1.3. Судалгааны хамрах хүрээ

Судалгааны түүврийн зохиомжийн үндсэн элементүүд болох эх олонлог, хамрах хүрээ, түүвэрлэлтийн нэгж, түүврийн үе шат болон бүлэглэлт, түүврийн хэмжээ болон түүний хуваарилалт, түүврийн хүрээ болон анхан шатны нэгжийн сонголт зэргийг тайлбарласан болно.

#### 1.3.1. Судалгааны эх олонлог, хамрах хүрээ, түүвэрлэлтийн нэгж

Судалгааны эх олонлог:	Улаанбаатар хотын гэр хорооллын өрх, өрхийн гишүүд байна.
Судалгааны хамрах хүрээ:	Улаанбаатар хотын 8 дүүргийн гэр хорооллууд байна.
Түүвэрлэлтийн нэгж:	Сонгогдсон дүүрэг, сонгогдсон хорооны гэр хороололд амьдардаг өрх, өрхийн гишүүд байна.

#### 1.3.2. Түүврийн зохиомж, хэмжээ, хуваарилалт

Судалгааны үр дүнд тооцогдох үндсэн үзүүлэлтүүдийг статистикийн хувьд бодитой байдлаар энгийн санамсаргүй түүврийг ашиглана.

Судалгааны түүврийн хэмжээг 1600 байхаар тооцов. Ингэхдээ өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй тус бүр 800 өрхөөс мэдээлэл цуглуулахаар тогтсон. Түүврийн хэмжээг тооцохдоо дараах томъёог ашиглав.

Үзүүлэлт	Утга	Тайлбар:	$n = \frac{Z^2 * p * (1 - p)}{D^2}$
p	0.5	p=0.5 үед түүврийн хамгийн их байх боломжтой.	
Z	2	95.4% итгэх магадлалтай үед Z утга 2 байдаг.	
D	0.0354	Алдааны магадлал буурах тусам түүврийн хэмжээ өснө.	

**Өрхийн интернетгүй өрх:**

Бодитоор гэр хорооллын өрхийн хэдэн хувь нь өрхийн интернет холбогдсон гэсэн албан ёсны тоон мэдээлэл байхгүй учир түүврийн хэмжээг хамгийн их байлгах зорилгоор  $p=0.5$  гэсэн утгыг шууд ашиглав.

$$n = \frac{Z^2 * p * (1 - p)}{D^2} = \frac{1.96^2 * 0.5 * (1 - 0.5)}{0.0354^2} = 798 \approx 800$$

**Өрхийн интернеттэй өрх:**

Бодитоор гэр хорооллын өрхийн хэдэн хувь нь өрхийн интернет холбогдоогүй гэсэн албан ёсны тоон мэдээлэл байхгүй учир түүврийн хэмжээг хамгийн их байлгах зорилгоор  $p=0.5$  гэсэн утгыг шууд ашиглав.

$$n = \frac{Z^2 * p * (1 - p)}{D^2} = \frac{1.96^2 * 0.5 * (1 - 0.5)}{0.0354^2} = 798 \approx 800$$

**Хүснэгт 1. Түүврийн хуваарилалт**

	Дүүрэг	Гэр хорооллын нийт өрхийн тоо	Дүнд эзлэх хувь	ТҮҮВЭР
1	Багануур дүүрэг	4 966	2.4%	40
2	Багахангай дүүрэг	528	0.3%	0
3	Баянгол дүүрэг	11 119	5.3%	85
4	Баянзүрх дүүрэг	49 255	23.7%	365
5	Налайх дүүрэг	7 806	3.8%	55
6	Сонгинохайрхан дүүрэг	67 669	32.5%	530
7	Сүхбаатар дүүрэг	17 584	8.5%	140
8	Хан-Уул дүүрэг	18 723	9.0%	150
9	Чингэлтэй дүүрэг	30 399	14.6%	235
	<b>НИЙТ</b>	<b>208 049</b>	<b>100.0%</b>	<b>1 600</b>

**1.4. Судалгааны аргазүй**

Тус судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны аргыг хослуулан цуглууллаа.

- Тоон судалгааны хувьд нүүр тулсан ярилцлагын аргаар (Face-to-Face-Interview) асуулгын хуудсаар мэдээлэл авсан. Асуулгын хуудас нь 40 орчим үндсэн асуулттайгаар зохиогдсон ба хүснэгт хэлбэрийн асуултууд болон дэд асуултуудыг задлан тооцвол 250 орчим асуулттай байлаа. Нэг асуулгын хуудсыг бөглүүлэхэд 20-25 минут зарцуулж байсан.
- Чанарын судалгааны хувьд Фокус бүлгийн ярилцлагын аргаар (Focus-Group) туршилтын 2 ярилцлага, үндсэн 6 ярилцлага буюу нийт 8 бүлэг ярилцлага хийлээ. Энэ хүрээнд Сонгинохайрхан дүүргийн Орбит, Тахилт, Толгойт, Баянхошуунд амьдардаг гэр хорооллын оршин суугчид, Сүхбаатар дүүргийн 14-р хороо Хайлааст чиглэлд амьдардаг иргэд, Чингэлтэй дүүргийн 12, 18-р хорооны төлөөлөл, Баянзүрх дүүргийн 9, 10, 12, 17, 34, 37-р хорооны төлөөлөл болох гэр хорооллын нийт  $8*8=64$  иргэд хамрагджээ. Чанарын судалгааны асуулга нь 1) Хувийн интернэт хэрэглээ, 2) Өрхийн интернэт хэрэглээ, 3) Өрхийн интернэтгүй хэрэглэгчийн хувьд гэсэн ерөнхий 3 агуулгад хуваагдаж агуулга тус бүр нь дотроо нарийвчилсан 40 орчим асуулттайгаар явагдсан. Фокус бүлгийн ярилцлага бүр харилцан адилгүй 45 минут-100 минут орчим үргэлжилсэн. Ярилцлагын дэлгэрэнгүй транскрипт хавсралтаар оруулж ерөнхий дүгнэлтийг тайланд тусгасан.

1.5. Судалгааны тайлан боловсруулах аргачлал, бүрэлдэхүүн

Судалгааны тайланг боловсруулахдаа асуулгын хуудсыг CSPRO 7.0 програмд оруулж, SPSS програмаар боловсруулалт хийгдэж дүнг нэгтгэсэн. Нэгтгэсэн дүнг хүснэгт, графикаар илэрхийлэн, шаардлагатай зарим харьцуулалтуудыг хийж тайланд тусгалаа. Мөн SPSS програмаас гаргасан нэгтгэсэн дүнг хавсралт хэсэгт оруулсан.

Тайлангийн бүрэлдэхүүн:

- ◆ Судалгааны тайлан
- ◆ Асуулгын хуудас
- ◆ SPSS дата
- ◆ Нэгтгэсэн хүснэгтүүд
- ◆ Фокус аудио
- ◆ Транскрипт (Word)

Нэг. ӨРХИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Энэ бүлгээр судалгаанд оролцогчдоос өрхтэй холбоотойгоор тодруулсан асуултын үр дүнг харуулна. Өрхийн сууцны төрөл, сарын орлого, харилцаа холбооны зардал, интернет холболт болон бусад үзүүлэлтүүд энд багтана.

1.1. Өрхийн сарын дундаж орлого, харилцаа холбооны зардал, бусад үзүүлэлт


Энэ бүлгээр судалгаанд оролцогчдын өрхийн сарын орлого, мэдээлэл, харилцаа холбооны зардал, харилцаа холбооны зардлын бүтэц зэрэг орлого, зарлагатай холбоотой асуултуудын үр дүнг ерөнхий болон тодорхой бүлгүүдээр харьцуулсан байдлаар харуулна.

Дараах асуултын зорилго нь нэг талаараа судалгаанд оролцогчдын амьжиргааны байдлыг тодруулах хэдий ч нөгөө талаараа интернет хэрэглээ болон бусад үнэлгээнд өрхийн орлогын нөлөө байгаа эсэхийг харьцуулан харах юм.

**Зураг 1. Судалгаанд оролцогчдын өрхийн сарын орлого**



**Зураг 2. Өрхийн сарын орлого, өрхийн интернет холболттой эсэх төрлөөр**



Судалгаанд оролцогчдын 59.2%-ийнх нь өрхийн сарын орлого 1 500 000 ба түүнээс бага байна. Энэхүү үзүүлэлт өрхийн интернеттэй айлуудын хувьд 51.2%, өрхийн интернетгүй айлуудын хувьд 67.0% байна. Өөрөөр хэлбэл өрхийн интернеттэй айлууд нь өрхийн интернетгүй айлуудаасаа харьцангуй орлого өндөр айлууд гэж хэлж болохоор байна. Эндээс өрхийн интернеттэй байх эсэхэд орлогын нөлөө байгааг харж болно.




Хэдийгээр өрхийн орлогын асуултыг бүлэглэсэн байдлаар асуусан ч бүлгийн дунджийн тусламжтайгаар өрхийн сарын дундаж орлогыг ойролцоогоор тооцоолов. Бүлгийн дундаж утгыг доорх хүснэгтээс харна.

**Хүснэгт 2.** Өрхийн дундаж орлого тооцоход ашиглагдахад бүлгийн мэдээлэл

	1	2	3	4	5	6
Орлогын бүлэг	100 000₮ - 500 000₮	500 000₮ - 1 000 000₮	1 000 000₮ - 1 500 000₮	1 500 000₮ - 2 000 000₮	2 000 000₮ - 2 500 000₮	3 000 000₮ дээш
Бүлгийн дундаж	300 000₮	750 000₮	1 250 000₮	1 750 000₮	2 250 000₮	3 250 000₮

**Зураг 3.** Өрхийн сарын дундаж орлого, тооцооллын утга, өрхийн интернет холболттой эсэх төрлөөр





Судалгаанд оролцогч өрхийн сарын дундаж орлогыг ойролцоо байдлаар тооцоолж үзэхэд 1395000₮ орчим байсан ба энэ тооцооллыг өрхийн интернеттэй болон интернетгүй гэсэн байдлаар харьцуулахад дунджаар 250000₮ орчмын зөрүү байгааг дээрх үр дүн харуулж байна.

Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгаагаар 2022 оны 1-р улиралд улсын дүнгээр өрхийн сарын дундаж орлого 1 646 360₮ байсан. (Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)) Судалгаанаас гарсан тооцооллын дүн болон Үндэсний статистикийн хорооны албан ёсны дүн хоёрыг харьцуулан харахад Улаанбаатар хотын гэр хорооллын иргэдийн орлого улсын дунджаас доогуур байна гэж үзэж болно.

Одоо судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж харилцаа холбооны зардлын талаар тодруулсан асуултын үр дүнг харуулна.

**Зураг 4.** Өрхийн сарын дундаж мэдээлэл, харилцаа холбооны зардлын хэмжээ, утга, өрхийн интернет холболттой эсэх төрлөөр




**Зураг 5.** Мэдээлэл, харилцаа холбооны зардлын өрхийн орлогод эзлэх хувь

Судалгаанд оролцсон өрхүүдийн сарын дундаж мэдээлэл, харилцаа холбооны зардал 83239₮ төгрөг байна. Энэ нь өрхийн сарын дундаж орлогын 6% орчимтой тэнцэж байна. Мэдээлэл, харилцаа холбооны зардлыг өрхийн интернеттэй эсэх байдлаар харьцуулан харахад өрхийн интернеттэй айлын зардал 30000₮ орчмоор илүү байна. Энэ зөрүү нь өрхийн интернетийн сарын дундаж зардал байх магадлалтай ба энэ талаар дараагийн бүлгээр илүү тодорхой харуулна.


Мэдээлэл, харилцаа холбоо, технологи нь гэр хорооллын иргэдийн өдөр тутмын зайлшгүй хэрэгцээ болсоныг мэдээлэл, харилцаа, холбоо, технологийн зардлын өрхийн орлогод эзлэх хувиас тодорхой харж болно. Өрхийн орлогын 5-7%-ийг зарцуулах хэмжээнд хүрсэн нь тийм ч бага үзүүлэлт биш юм.

Өрхийн мэдээлэл, харилцаа холбооны зардлын бүтцийг доорх зургаар харуулав.

**Зураг 6.** Өрхийн сарын дундаж мэдээлэл, харилцаа холбооны зардлын бүтэц

Өрхийн мэдээлэл, харилцаа холбооны зардлын 60% орчмын өрхийн гишүүдийн гар утасны нэгж, төлбөр буюу үүрэн холбооны үйлчилгээнд зарцуулагдаж байна.

Судалгаанд оролцогчдын 59% орчим нь хувийн байшинд амьдардаг бол 38% орчим нь гэрт, үлдсэн хэсэг нь нийтийн байр гэх мэт бусад сууцанд амьдардаг.


**Зураг 7.** Судалгаанд оролцогчдын амьдардаг сууцны төрөл

## 1.2. Өрхийн интернет ашиглах боломжит төхөөрөмж, интернет холболт, хугацаа

Энэхүү бүлгээр өрхийн интернет ашиглах боломжит төхөөрөмжийн талаар болон өрхийн интернеттэй айлуудын хувьд ямар компанийн өрхийн интернет ашиглаж буй талаар тодруулсан асуултын үр дүнг танилцуулна.

Интернет ашиглах боломжтой төхөөрөмжийн хувьд хамгийн түгээмэл нь гар утас байна. Огт утасгүй эсвэл ухаалаг утасгүй цөөн тооны бүлэг л энэ үр дүнгээс хасагдаж байна. Гар утсыг эс тооцвол хамгийн түгээмэл нь компьютер бөгөөд давхардсан тоогоор судалгаанд оролцогч өрхүүдийн 38% орчим нь компьютертой байна. Өөрөөр хэлбэл судалгаанд оролцогч 3 өрх тутмын 1 нь нөүтбүүк эсвэл суурин компьютертой байна.


**Зураг 8.** Интернет ашиглах боломжтой төхөөрөмж байгаа эсэх үнэлгээ



Асуулгын хуудас дээр өрхийн гишүүн бүрээс гар утастай эсэх, интернет ашигладаг эсэхийг асуусан асуулт оруулж өгсөн бөгөөд гар утастай эсэх үнэлгээг насны бүлгээр дор харуулав. Хэдийгээр манай судалгааны түүврийн хэмжээ 1600 ч энэ асуултын хувьд түүврийн хэмжээ 6200 орчим болж өссөнийг энд онцлох хэрэгтэй юм.


Үр дүнгээс харахад 5-9 насны 3 хүүхэд тутмын 1 нь гар утастай байна. Энэ үзүүлэлт 10-15 насны хувьд 5 хүүхдийн 4 нь гар утастай болж өссөн байна. Эндээс 10 хүртэлх насны хүүхдүүдийн хувьд өрхийн амьжиргааны төвшин, амьдралын хэв маяг, насны хязгаарлалт гэх мэт олон шалтгааны улмаас гар утасгүй байж болох ч 10 ба түүнээс дээш насандаа дийлэнх нь гар утастай болдгийг доорх үр дүн харуулж байна. 10 ба түүнээс дээш настай хүүхдүүдийн хувьд гар утастай байна гэдэг нь насанд хүрэгчидтэй ойролцоо төвшинд зайлшгүй хэрэгцээ болсныг энэхүү үр дүн харуулж байна.

**Зураг 9.** Гар утастай эсэх, насны бүлгээр, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн



Утасны төрлийн хувьд дийлэнх нь ухаалаг утас хэрэглэдэг ба 55+ насны бүлэгт энгийн утасны хэрэглээ тодорхой хэмжээнд байна.


Зураг 10. Гар утастай эсэх, насны бүлгээр, утасны төрлөөр



Түүврийн хувьд өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй гэж харьцуулах үүднээс тэнцүү хэмжээтэй авсан бөгөөд судалгаанд оролцсон өрхийн интернеттэй бүлгээс хэрэглэсэн хугацааны талаар тодруулсан асуултын үр дүнг дор харуулав.

Өрхийн интернеттэй 3 өрх тутмын 1 нь жил хүрэхгүй хугацаанд тухайн интернетийг хэрэглэж байгаа гэж хариулсан байна. Эндээс гэр хорооллын өрхийн интернетийн хэрэглээ хэрхэн хурдацтай өсөж байгаа нь тодорхой харагдаж байна.


Зураг 11. Өрхийн интернет хэрэглэсэн хугацаа, өрхийн интернеттэй=100%



Өрхийн интернеттэй айлуудын хувьд ямар байгууллагын интернетийг хэрэглэдэг тухай асуултын үр дүнг дор харуулав.

Үр дүнгээс харахад өрхийн интернеттэй 5 өрх тутмын 2 нь ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээг ашиглаж байна. ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээ нь анх танилцуулагдаж, зах зээлд нэвтрэхдээ төхөөрөмжөө үнэгүй өгөх маркетингийг ашигласан нь гэр хорооллын өрхийн интернетийн зах зээлийн тэргүүлэгч үйлчилгээ болоход нөлөөлсөн. Сүүлийн жилүүдэд Юнивишн компани орон нутаг болон Улаанбаатар хотын гэр хороолол руу дэд бүтцээ оруулж, нэвтэрч эхэлсэн ба хэрхэн хурдацтай байгааг доорх үр дүн тодорхой харуулж байна.

Зураг 12. Өрхийн интернет үйлчилгээ авдаг байгууллага, өрхийн интернеттэй=100%



Өрхийн интернеттэй айлуудын интернет үйлчилгээний сарын дундаж зардлын талаарх асуултын үр дүнг дор харуулав.

Өрхийн интернетийн сарын дундаж зардал 30000₮ орчим төгрөг байна. Өмнөх бүлгээр мэдээлэл, харилцаа холбооны зардлыг өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй гэж харьцуулсан байдлаар харуулахад зөрүү мөн 30000₮ орчим байсан. Өөрөөр хэлбэл өрхийн интернетийн зардлыг эс тооцвол бусад мэдээлэл, харилцаа холбооны зардал өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй өрхүүдийн хувьд ойролцоо байна.

Өрхийн интернетийн зардлыг зарим нь гол үйлчилгээ үзүүлэлгч компаниар задлан харахад Юнивишний үйлчилгээ авдаг өрхүүд дунджаар сард 43800₮ гэж хариулжээ. Гэхдээ энэ нь зөвхөн интернетийн зардал гэхээсээ илүүтэйгээр багцын зардал байх магадлалтай бөгөөд телевизийн олон сувгийн үйлчилгээний төлбөр энд багтсан гэж ойлгож болохоор байна.

Гэр интернетийн хувьд дундаж зардал 28000₮ байна. Өрхүүдийн хувьд ихэвчлэн 30 хоногийн хугацаатай багцыг авч ашигладаг бөгөөд тэдгээр багцууд нь датаны хэмжээнээс хамаараад 25000₮ болон 40000₮ гэсэн сонголттой байна.

**Зураг 13.** Өрхийн интернет үйлчилгээний сарын дундаж зардал, зарим байгууллагаар



### 1.3. Интернет холбогдоогүй шалтгаан, ирээдүйн төлөвлөгөө

Түүврийн хувьд өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй гэж харьцуулах үүднээс тэнцүү хэмжээтэй авсан бөгөөд судалгаанд оролцсон өрхийн интернетгүй бүлгээс холбогдоогүй шалтгааны талаар тодруулсан асуултын үр дүнг дор харуулав.


**Зураг 14.** Интернетэд холбогдоогүй шалтгаан, өрхийн интернетгүй=100%

1	Гар утасны дата ашиглаад интернэт хэрэглээгээ шийдчихдэг.	54.6%
2	Өрхийн интернэтийн үйлчилгээ авах боломжгүй газар амьдардаг	18.1%
3	Үйлчилгээний үнэ өртөг өндөр, төлөх боломжгүй.	17.0%
4	Смарт утас, компьютер зэрэг интернэт ашиглах төхөөрөмжийн өртөг өндөр байна.	8.9%
5	Интернэт хэрэглэх шаардлага огт байхгүй.	4.6%
6	Интернэт үйлчилгээ авах боломжтой боловч өрхийн хэрэгцээнд нийцдэггүй.	4.4%
7	Ажил, сургууль болон бусад газар хэрэглээд болчихдог.	3.2%
8	Хөршийн wi-fi –г одоохондоо ашиглаж байна.	1.4%
9	Гэрт интернэт холболт байх нь буруу гэж үздэг (эрүүл мэндэд сөрөг, хүүхдэд буруу зуршил үүсгэдэг гэх мэт)	1.0%
10	Бусад:	0.9%
11	Гэр орчмын нийтийн үнэгүй wi-fi –г одоохондоо ашиглаж байна.	0.7%
12	Нууцлал, аюулгүй байдлын асуудлаас	0.4%

Судалгаанд оролцогч өрхийн интернетгүй 2 өрх тутмын 1 нь гар утасны дата ашиглаад интернет хэрэглээгээ шийдчихдэг гэж хариулжээ. Эндээс нэг талаараа боломжит дэд бүтцийн хүрээнд өөрсдийн хэрэгцээгээ хангачихдаг гэж дүгнэж болохоор байна. Энэ нь фокус бүлгийн ярилцлагын агуулгаас ч тод илэрч байлаа. Гэхдээ интернет хэрэглэх шаардлага огт байхгүй гэсэн хариулт ердөө 4.6% байгаагаас харахад интернет хэрэглээ гэр хорооллын иргэдийн өдөр тутмын байнгын хэрэглээ болсныг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл илүү хямд, чанартай үйлчилгээ, дэд бүтэц нэвтэрсэн тохиолдолд хэрэглэгчийн зах зээл хангалттай байгааг эндээс харж болохоор байна.

Одоо өрхийн интернетгүй өрхүүд ирээдүйд интернеттэй болох төлөвлөгөө байгаа эсэхийг тодруулсан асуултын үр дүнг дор харуулав.

Өрхийн интернетгүй 2 айл тутмын 1 нь өрхийн интернеттэй болох төлөвлөгөөтэй гэж хариулсан нь дээр дурдсан хямд, чанартай үйлчилгээ, дэд бүтэц нэвтэрсэн тохиолдолд хэрэглэгчийн зах зээл хангалттай байгаа гэсэн дүгнэлтийг баталж байна.

**Зураг 15.** Өрхийн интернеттэй болох төлөвлөгөө байгаа эсэх, өрхийн интернетгүй=100%

Өрхийн интернетгүй болон Юнивишнээс бусад үйлчилгээ авдаг өрхүүдээс шилэн кабелийн суурин интернет ашиглах боломж бүрдвэл ашиглах эсэх талаар тодруулсан асуултын үр дүнг дор харуулав. Энэхүү агуулга фокус бүлгийн ярилцлагын агуулга дээр илэрч, үр дүнг бататгаж байна.

Тус асуултад хариулт өгсөн нийт оролцогчдын 37% нь боломж бүрдсэн даруйд шууд хэрэглэгч болоход бэлэн гэдгээ илэрхийлсэн бөгөөд ямар нэг байдлаар ашиглахгүй, ашиглах боломжгүй гэсэн хариултын нийлбэр ердөө 10% орчим байгаа нь хангалттай зах зээл байгааг дахин харуулж байна.

**Зураг 16.** Шилэн кабелийн суурин интернет ашиглах боломж бүрдвэл ашиглах эсэх, (Юнивишн хэрэглэгчээс бусад бүх оролцогч=100%)



Энэ бүлгийн үр дүнгүүд гэр хороолол руу шилэн кабел татах, дэд бүтцийг шийдэх эрэлт, хэрэгцээ хангалттай их байгааг баталж буй бөгөөд ямар байгууллага, хэрхэн, яаж нэвтрүүлэх нь зайлшгүй анхаарах, ярилцах сэдвүүдийн нэг юм.

## Хоёр. ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭЭ


Энэ бүлгээр судалгаанд оролцогч хувь хүний өөрийнх нь интернет хэрэглээний талаар тодруулсан асуултын үр дүнг танилцуулна. Интернет хэрэглэдэг эсэх, хэрэглэдэг бол давтамж, байршил болон зорилго, хэрэглэдэггүй бол шалтгааныг тодорхой сегментээр харьцуулсан үр дүн болон бусад үзүүлэлтүүд энд багтана.

### 2.1. Интернет хэрэглээ, давтамж, байршил болон зорилго

Асуулгын хуудас дээр өрхийн гишүүн бүрээс гар утастай эсэх, интернет ашигладаг эсэхийг асуусан асуулт оруулж өгсөн бөгөөд интернет хэрэглэдэг эсэх үнэлгээг насны бүлгээр дор харуулав. Хэдийгээр манай судалгааны түүврийн хэмжээ 1600 ч энэ асуултын хувьд түүврийн хэмжээ 6200 орчим болж өссөнийг энд онцлох хэрэгтэй юм.

Үр дүнгээс харахад хүүхдийн интернет хэрэглээ 10 наснаас эрс өсөж байна. 16-54 насны хувьд интернет хэрэглээ маш өндөр буюу 90+ хувьтай байна. Харин 65+ насны бүлгийн хувьд интернет хэрэглээ харьцангуй бага буюу 47.5% байна.


**Зураг 17.** Интернет хэрэглэдэг эсэх үнэлгээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн



Судалгааны үндсэн буюу асуулгын хуудсыг бөглөсөн оролцогчдын хувьд интернет хэрэглээ ямар төвшинд байсныг дор харуулав.

Судалгаанд оролцогчдын 86.6% нь интернет ямар нэг байдлаар хэрэглэдэг гэж хариулсан нь интернет хэрэглээ ямар хурдацтай тархаж, өдөр тутмын зайлшгүй хэрэгцээт үйлчилгээ болсныг харуулах бас нэг үзүүлэлт болж байна.

**Зураг 18.** Интернет хэрэглэдэг эсэх үнэлгээ, үндсэн асуулт буюу судалгаанд оролцогчдын хувьд




Өрхийн интернеттэй эсэхээр харьцуулан харахад интернет хэрэглээ бага зэрэг зөрүү ажиглагдаж байна. Гэхдээ өрхийн интернетгүй ч 81.6% нь интернет хэрэглэдэг гэж хариулсан нь тийм бага үзүүлэлт биш бөгөөд өрхийн интернеттэй байхаас үл хамааран өдөр тутмын зайлшгүй хэрэглээ болсныг батлах бас нэг үзүүлэлт болж байна.

**Зураг 19.** Интернет хэрэглэдэг эсэх үнэлгээ, өрхийн интернеттэй эсэх үнэлгээгээр



Интернет хэрэглэдэг оролцогчдын хэрэглэх давтамжийн талаар тодруулсан асуултын үр дүнг дор харуулав. Үр дүнгээс харахад судалгаанд оролцогч интернет хэрэглэдэг 2 хүн тутмын 1 нь өдөрт 3-аас илүү цагийг интернет хэрэглэхэд зарцуулдаг байна. Интернет хэрэглэдэг оролцогчдын 96.3% нь өдөр бүр интернет хэрэглэдэг гэж хариулсан нь өмнөх бүлгүүдэд дурдсан интернет нь өдөр тутмын зайлшгүй хэрэгцээ болсныг батлах бас нэг үзүүлэлт болж байна.

**Зураг 20.** Судалгаанд оролцогчдын интернет ашиглах давтамж, интернет хэрэглэдэг=100%



Давтамжийг насны бүлгээр харахад 16-24 насны оролцогчдын 64.7% нь өдөрт 3-аас илүү цагийг интернет хэрэглэдэг гэж хариулсан нь бусад бүлгүүдтэй харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт байна.

**Хүснэгт 3.** Судалгаанд оролцогчдын интернет ашиглах давтамж, насны бүлэг бүрийн интернет хэрэглэдэг=100%

		16-24	25-34	35-44	45-54	55+
1	Өдөрт 3 цагаас илүү	64.7%	49.9%	41.3%	33.9%	26.4%
2	Өдөрт 2-3 цаг	17.8%	24.3%	22.3%	23.5%	18.7%
3	Өдөрт 1-2 цаг	14.1%	18.8%	28.4%	25.5%	25.3%
4	Өдөрт 1 цагаас бага	2.5%	4.3%	4.1%	10.8%	23.6%
5	Өдөр бүр биш	0.8%	2.6%	3.9%	6.4%	6.0%
#	НИЙТ	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Интернет хэрэглэх давтамжийг насны бүлгээр задлан харуулахад залуучуудын интернетэд зарцуулж буй хугацаа илүү байгааг ерөнхий байдлаар харж болох ч яг тодорхой, ойлгомжтой байдлаар харуулах шаардлага тулгарч байна. Иймд хариулт тус бүрд тодорхой оноо өгч индекс




хэлбэр лүү шилжүүлэх замаар тодорхой, ойлгомжтой харагдуулахыг зорилоо. Индекс хэлбэр лүү шилжүүлэхдээ дараах оноог өгч тооцоолол хийсэн.

Өдөрт 3 цагаас илүү	Өдөрт 2-3 цаг	Өдөрт 1-2 цаг	Өдөрт 1 цагаас бага	Өдөр бүр биш
5	4	3	2	1

Индексийн үр дүнгээс харахад нас ахих тусам интернетэд зарцуулах хугацаа багасаж байгаа нь тодорхой харагдаж байна.

**Зураг 21.** Судалгаанд оролцогчдын интернет ашиглах давтамжийг оноонд шилжүүлсэн тооцоолол, насны бүлгээр



Интернетийг хаана хэрэглэдэг тухай тодруулсан асуултын үр дүнгээр судалгаанд оролцогчдын 98-99% буюу дийлэнх хэсэг нь ажлын болон амралтын өдрөөр аль алинд гэртээ интернет хэрэглэдэг гэж хариулжээ. Эндээс гэрийн буюу өрхийн интернетийн эрэлт, хэрэгцээ хангалттай байгааг харж болохоор байна.

**Зураг 22.** Судалгаанд оролцогчдын интернет хэрэглэх байршил



Байршил тус бүрийн интернет хэрэглээг илүү нарийвчлалтайгаар буюу хэрэглэх давтамжаар дараах 2 хүснэгтээр харуулав. Судалгаанд оролцогч интернет хэрэглэдэг хүмүүсийн 83.5% нь ажлын өдрүүдэд өдөр бүр гэртээ интернет хэрэглэдэг бол энэ үзүүлэлт амралтын өдрүүдэд 96.1% болтол өссөн байна. Энэ үр дүн гэрийн интернет хэрэглээ ямар төвшинд байгааг илүү тодорхой харуулж буй бөгөөд одоогийн төвшнөөс илүү чанартай, боломжийн үнэтэй технологи нэвтэрвэл эрэлт, хэрэгцээ хангалттай байгааг судалгааны үр дүнгүүд харуулсаар байна.

**Хүснэгт 4. Ажлын өдрөөр интернет хэрэглэх давтамж, байршлаар**

	Байршил	Өдөр бүр	Долоо хоногт хэд хэдэн удаа	Долоо хоногт нэг удаа	Сард хэд хэдэн удаа	Сард нэг удаа	Огт ашиглаагүй	НИЙТ
1	Гэртээ	<b>83.5%</b>	6.5%	4.7%	2.2%	1.1%	2.0%	100.0%
2	Ажил эсвэл сургууль дээрээ	<b>43.1%</b>	<b>11.5%</b>	4.2%	1.2%	0.8%	39.3%	100.0%
3	Айлд	3.5%	3.2%	4.3%	9.7%	8.8%	70.5%	100.0%
4	Нийтийн интернеттэй газар (номын сан, кофе шоп гэх мэт)	3.5%	6.5%	2.7%	4.7%	3.5%	79.1%	100.0%
5	Төлбөртэй интернеттэй газар	1.4%	1.0%	1.1%	1.7%	2.8%	92.0%	100.0%
6	Дээрхээс бусад газруудад	6.7%	1.7%	0.8%	1.7%	3.1%	86.0%	100.0%

**Хүснэгт 5. Амралтын өдрөөр интернет хэрэглэх давтамж, байршлаар**

	Байршил	Өдөр бүр	Долоо хоногт нэг удаа	Сард хэд хэдэн удаа	Сард нэг удаа	Огт ашиглаагүй	НИЙТ
1	Гэртээ	<b>96.1%</b>	1.9%	0.5%	0.2%	1.3%	100.0%
2	Ажил эсвэл сургууль дээрээ	<b>17.9%</b>	4.5%	4.9%	4.5%	68.2%	100.0%
3	Айлд	5.3%	3.8%	9.6%	6.9%	74.4%	100.0%
4	Нийтийн интернеттэй газар (номын сан, кофе шоп гэх мэт)	6.8%	3.7%	2.8%	3.2%	83.5%	100.0%
5	Төлбөртэй интернеттэй газар	2.4%	0.9%	1.2%	2.9%	92.7%	100.0%
6	Дээрхээс бусад газруудад	6.0%	1.4%	1.9%	2.7%	87.9%	100.0%

Өмнөх үр дүнгүүдээс интернет хэрэглээ нь өдөр тутмын байнгын хэрэглээ болсныг тодорхой харсан. Тэгвэл тэрхүү хэрэглээг гар утасны дата эсвэл өөр хэлбэрээр шийдэж байгаа эсэхийг тодруулсан үр дүнг дор харуулав.


Үр дүнгээс харахад интернет хэрэглээгээ ихэвчлэн гар утасны датагаар шийддэг болох нь харагдаж байна. Хэдийгээр судалгаанд оролцогчдын 50% орчим нь өрхийн интернеттэй хэдий ч гэртээ “тухайн байгаа орчны суурин интернет” ашигладаг гэж хариулсан 29% байна. Эдгээр тоог харьцуулж үзвэл өрхийн интернеттэй байсан ч гэртээ гар утасны дата хэрэглэдэг хандлага байгааг харж болно.

**Зураг 23. Судалгаанд оролцогчдын интернет ашиглах төрөл**

Өрхийн гишүүн тус бүрээс интернет хэрэглэх төрлийн асуусан ба гар утасны датанаас бусад хэлбэрээр эсвэл аль алинаар нь хэрэглэдэг гэсэн үзүүлэлтүүдийн нийлбэрийг дараах үр


дүнгээр харуулав. Үр дүнгээс харахад насны бүлэг тус бүрээр гар утасны датанаас бусад хэлбэрийн хэрэглээ хамгийн ихдээ 41-42%-тай байна. Харин энэ үзүүлэлт гар утасны датаны хувьд 90+% байсан ба дараагийн бүлгээр дэлгэрэнгүй харуулна.

**Зураг 24.** WiFi, өрхийн суурин интернетийн хэрэглээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн




Интернет ашиглах төхөөрөмжийн хувьд гар утас хамгийн их тархсан төхөөрөмж байна. Өмнөх бүлгээр ч энэхүү үр дүн тодорхой харагдсан бөгөөд 95.4% нь гар утастай байсныг харуулж байсан. Энэхүү үзүүлэлт нь чанарын судалгааны үр дүнгээр ч мөн бататгасан үзүүлэлт юм.

**Зураг 25.** Судалгаанд оролцогчдын интернет ашиглах төхөөрөмж



Интернет ашиглах зорилгын хувьд Нийгмийн сүлжээ ашиглах, бүх төрлийн чатаар харилцах гэсэн шалтгаанууд бусдаас илт өндөр үзүүлэлттэй байна. Эдгээр шалтгаанууд аль аль нь “Харилцаа холбоо, иргэний оролцоо, хамтын ажиллагаа” гэсэн бүлэгт хамаарч байна.

**Зураг 26.** Судалгаанд оролцогчдын интернет ашиглах ТОП10 зорилго



Хамгийн өндөр үзүүлэлттэй шалтгаануудын агуулгыг харваас ажил хэрэгтэй холбоотой гэхээсээ илүүтэйгээр мэдээлэл солилцох, чөлөөт цагаа өнгөрөөх зорилго бүхий шалтгаанууд давамгайлж байгаа нь харагдлаа.

**Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын интернет ашиглах зорилго**


№	Төрөл	Дэд төрөл	ТИЙМ	ҮГҮЙ	НИЙТ
1.	Мэдээлэл авахаар	Сонин, сэтгүүл эсвэл цахим ном унших, татаж авахаар	40.0%	60.0%	100.0%
		Төрийн байгууллагуудаас мэдээлэл авахаар	49.0%	51.0%	100.0%
		Эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл (Гэмтэл, өвчих, хоол тэжээл хайж олохоор)	54.7%	45.3%	100.0%
2.	Харилцаа холбоо, иргэний оролцоо, хамтын ажиллагаа	Нийгмийн сүлжээ (Facebook, Instagram, Twitter гм) орохоор	94.2%	5.8%	100.0%
		Мэйлээ шалгах аар	51.7%	48.3%	100.0%
		Бүх төрлийн чатаар харилцах аар	78.1%	21.9%	100.0%
		Төрийн байгууллагуудтай харилцах – маягт, өргөдөл татах, зөвлөлдөх уулзалт, интернетээр санал өгөх зэргээр	30.0%	70.0%	100.0%
3.	Цахим худалдаа, худалдаа үйлчилгээ	Онлайнаар бараа худалдах авах, захиалахаар	39.3%	60.7%	100.0%
		Онлайнаар бараа зарах, захиалахаар	26.0%	74.0%	100.0%
		Интернет банк ашиглахаар	59.2%	40.8%	100.0%
4.	Ажил хэргийн шугамаар	Ажилд орох анкет онлайнаар бүртгүүлэхээр	19.2%	80.8%	100.0%
		Бусад ажил хэргийн шугамаар сүлжээнд холбогдохоор	27.5%	72.5%	100.0%
		Үндсэн ажлаа цахимаар хийхээр	22.3%	77.7%	100.0%
5.	Боловсрол	Цахим хичээл хийлгэхээр	33.8%	66.2%	100.0%
		Онлайн сургалтуудад оролцохоор	27.0%	73.0%	100.0%
		Онлайн сургал хийхээр	18.2%	81.8%	100.0%
		Цахим толь ашиглахаар	29.3%	70.7%	100.0%
6.	Эрүүл мэнд	Шинжилгээний хариу хүлээн авах, харахаар	34.8%	65.2%	100.0%
		Эмчийн цаг товлохоор	31.1%	68.9%	100.0%
		Шинжилгээний цаг товлохоор	26.2%	73.8%	100.0%
7.	Дижитал контент үүсгэх	Вэб сайтад өөрөө – Хэрэглэгчийн бүтээсэн агуулгыг байршуулах	12.4%	87.6%	100.0%
		Интернетэд хадгалах зайг ашиглан баримт бичиг байршуулах	14.9%	85.1%	100.0%
		Зураг, хөгжим, видео хадгалах	30.7%	69.3%	100.0%
8.	Үзвэр үйлчилгээ, дижитал агуулгын хэрэглээ	Вэбээр радио сонсох	29.6%	70.4%	100.0%
		ТВ үзэхээр	40.5%	59.5%	100.0%
		Кино үзэхээр	56.9%	43.1%	100.0%
		Видео эсвэл хөгжим дамжуулах эсвэл татаж авахаар	49.4%	50.6%	100.0%
		Тоглоом тоглохоор	46.2%	53.8%	100.0%
		Төрөл бүрийн зураг үзэхээр	46.2%	53.8%	100.0%

## 2.2. Гар утасны дата хэрэглээтэй холбоотой зарим үзүүлэлт

Өмнөх бүлгээр интернет хэрэглээ тэр дундаа гар утасны дата хэрэглээ өндөр байгааг олон үзүүлэлт батлан харуулсан. Энэ бүлгээр гар утасны дататай холбоотой тодруулсан цөөн асуултын үр дүнг харуулна. Үүнд дата хэрэглээний хэмжээ, зардал болон хэрэглээний шийдэл гэх мэт үр дүнгүүд багтана.


Гар утасны дата хэрэглээг өрхийн гишүүн бүрийн асуултаар давхар тодруулсан ба насны бүлэг тус бүрийн ерөнхий интернет хэрэглээнээс хамаарч гар утасны дата хэрэглээ тодорхой хэмжээнд ялгаатай байгааг дараах зургаас харж болно. 16-44 насны бүлгийн хувьд дата хэрэглээ хамгийн өндөр түвшинд байна.

**Зураг 27.** Гар утасны дата хэрэглээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн, бүлэг тус бүрийн нийт оролцогчийг 100% гэж тооцсон.



Дээрх үр дүн нь бүлэг тус бүрийн интернет хэрэглэдэг болон хэрэглэдэггүй бүх оролцогчийн 100% гэж тооцсон. Харин дараах зургаар бүлэг тус бүрийн зөвхөн интернет хэрэглэдэг бүлгийг 100% гэж тооцоход гар утасны дата хэрэглээ ямар төвшинд байгааг харуулав. Үр дүнгээс харахад бүлэг тус бүрийн интернет хэрэглэдэг оролцогчдын багадаа 87% нь гар утасны дата хэрэглэдэг гэсэн маш өндөр үзүүлэлт гарч байна.

**Зураг 28.** Гар утасны дата хэрэглээ, өрхийн гишүүн тус бүрийн асуултын үр дүн, бүлэг тус бүрийн интернет хэрэглэдэг оролцогчийг 100% гэж тооцсон.




Судалгаанд оролцогчдын 91.7% нь гар утасны дата хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл насанд хүрсэн 10 хүн тутмын 9 нь гар утасны дата ямар нэг байдлаар хэрэглэдэг. Үүнийг өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй оролцогчдоор харьцуулан харахад бага зэрэг ялгаатай байгаа ч аль аль нь өндөр төвшинд байгаа нь тодорхой харагдаж байна. Эндээс өрхийн интернеттэй болсон ч гар утасны дата хэрэглээний төвшин буурахгүй байх хандлага байгааг харж болно.

**Зураг 29.** Судалгаанд оролцогчдын гар утасны дата хэрэглэх байдал




**Зураг 30.** Судалгаанд оролцогчдын гар утасны дата хэрэглэх байдал, харьцуулалт




Гар утасны дата хэрэглэдэг судалгаанд оролцогчдын дийлэнх хэсэг нь багадаа 1GB дата түүнээс илүү хэрэглэдэг болох нь дараах зургаас тодорхой харагдаж байна. Судалгаанд оролцогч гар утасны дата хэрэглэдэг 3 хүн тутмын 2 нь сард 5GB ба түүнээс илүү хэмжээний дата хэрэглэдэг гэж хариулсан нь интернет хэрэглээ, тэр дундаа гар утасны дата хэрэглээ ямар өндөр төвшинд хүрснийг батлах бас нэг үзүүлэлт болж байна.

**Зураг 31.** Судалгаанд оролцогчдын сард ашигладаг датаны хэмжээ, дата хэрэглэдэг 100%




Гар утасны дата хэрэглээг өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй оролцогчдын бүлгээр харьцуулан харахад өрхийн интернетгүй хэсэг нь гар утасны дата тодорхой хэмжээнд илүү хэрэглэдэг нь харагдлаа. Өрхийн интернетгүй оролцогчдын 47.6% нь сард 10GB ба түүнээс илүү дата хэрэглэдэг гэсэн үзүүлэлттэй байгаа бол энэ үзүүлэлт өрхийн интернеттэй бүлгийн хувьд 37.5% буюу 10 пунктээр бага байна. Энэхүү үзүүлэлт нь чанарын судалгааны агуулгатай ижил агуулгаар илэрч байгаа нь үр дүнг улам бататгасан үзүүлэлт болсон.

**Зураг 32.** Судалгаанд оролцогчдын сард ашигладаг датаны хэмжээ, харьцуулалт



Гар утасны дата хэрэглээг насны бүлгээр харьцуулан харах зорилгоор зөвхөн 10GB ба түүнээс илүү хэрэглээтэй үзүүлэлтийг дор харуулав. Ингэхэд нас залуу байх тусмаа хэрэглэж буй датаны хэмжээ их байгааг харж болохоор байна. Өөрөөр хэлбэл гар утасны дата хэрэглээний хэмжээнд насны нөлөө байна гэж тодорхойлж болно.

**Зураг 33.** Сард багадаа 10GB дата хэрэглэдэг хувь, насны бүлгээр




**Хүснэгт 7.** Судалгаанд оролцогчдын сард ашигладаг датаны хэмжээ, насны бүлгээр

	Насны бүлэг				
	16-24	25-34	35-44	45-54	55+
1GB хүртэл	2.6%	2.8%	5.4%	7.9%	9.5%
1 – 5 GB	15.9%	19.9%	18.5%	22.4%	26.6%
5 – 10 GB	19.4%	22.7%	27.1%	27.2%	25.3%
10 – 30 GB	27.3%	28.3%	27.7%	19.7%	14.6%
30 GB-аас их	29.5%	19.6%	15.2%	11.8%	8.9%
Хариулж мэдэхгүй	5.3%	6.5%	6.3%	11.0%	15.2%
	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Гар утасны дата хэрэглээ маш өндөр, хэмжээний хувьд ч өндөр байгаа нь дээрх үр дүнгүүдээс харагдсан. Тэгвэл датагаа хэрхэн шийддэг, сард дунджаар хэдэн төгрөгийн зардал гардаг талаар тодруулсан асуултуудын үр дүнг дор харуулав.

Үр дүнгээс харахад 2 оролцогч тутмын 1 нь нэмэлт дата багц авч ашигладаг ба сард дунджаар 27-28 мянган төгрөгийг зарцуулдаг байна. Өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй оролцогчдын хувьд гар утасны датад зарцуулах зардал төдийлөн ялгаа ажиглагдсангүй.

**Зураг 34.** Гар утасны датагаа хэрхэн шийддэг тухай**Зураг 35.** Нэмэлт дата авахад зарцуулж буй сарын дундаж зардал

Судалгаанд оролцогч 5 хүн тутмын 4 нь гар утасны датаг гэртээ хэрэглэдэг бол 5 хүн тутмын 2 нь ажил болон бусад газарт хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл гар утасны дата хэрэглэх хамгийн түгээмэл газар нь гэртээ хэрэглэх байна.


**Зураг 36.** Судалгаанд оролцогчдын гар утасны дата хэрэглэдэг байршил

2.3. ГЭРТЭЭ интернет хэрэглэдэг эсэх тухай зарим үзүүлэлт


Өмнөх бүлгүүдээр интернет хэрэглээ өдөр тутмын хэрэгцээ болсон ба гэртээ интернет хэрэглээ нь чөлөөт цагаа өнгөрөөх хамгийн том зүйл болсныг олон үзүүлэлтээр харуулсан. Энэ бүлгээр гэртээ интернет хэрэглэдэг эсэх, ямар зорилгоор интернет хэрэглэдэг гэх мэт зөвхөн гэрийн хэрэглээнд төвлөрсөн цөөн асуултын үр дүн энэ бүлгээр харуулна.

Судалгаанд оролцогч интернет хэрэглэдэг бараг бүх хүн буюу оролцогчдын 99.6% гэртээ ямар нэг байдлаар интернет хэрэглэдэг байна. Нийт интернет хэрэглээний хэдэн хувийг ГЭРТЭЭ хэрэглэдэг тухай асуухад 14.4% нь л 91-100% гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл зөвхөн гэртээ л интернет хэрэглэдэг бүлэг бага байгааг харж болно. Эндээс нэг талаараа гэрээс өөр газар ч интернет хэрэглэх хандлага их байгааг харуулж байна.

**Зураг 37.**  
ГЭРТЭЭ  
интернет  
хэрэглэдэг  
төвшин



**Зураг 38.** Нийт интернет хэрэглээний хэдэн хувийг ГЭРТЭЭ хэрэглэдэг тухай үр дүн



Өмнөх бүлгээр харуулсан байршил хамаагүйгээр интернет ашиглах зорилгуудыг нийгмийн сүлжээ тэргүүлж байсан бол гэртээ интернет ашиглах зорилгыг ч мөн нийгмийн сүлжээ тэргүүлж байна. Өөрөөр хэлбэл нийгмийн сүлжээ гэдэг хаана ч байсан хүмүүсийн интернет хэрэглэх гол зорилгуудын нэг болсныг дахин баталж байна.


**Зураг 39.** Судалгаанд оролцогчдын ГЭРТЭЭ интернет ашиглах зорилго






Судалгаанд оролцогч интернет хэрэглэдэг 2 оролцогч тутмын 1 нь шилэн кабелийн интернет ашиглах боломж бүрдвэл гэртээ интернет ашиглах хэмжээ, хугацаа өснө гэж төсөөлж байна. Шилэн кабелийн интернет ашиглах боломж бүрдсэн тохиолдолд хэмжээ, хугацаа өснө гэсэн хүлээлт өрхийн интернетгүй айлуудын хувьд өрхийн интернеттэй айлуудаас илүү өндөр байна.

**Зураг 40.** Шилэн кабелийн интернет ашиглах боломж бүрдвэл ГЭРТЭЭ интернет ашиглах хэмжээ, хугацаа өсөх тухай төсөөлөл



**Зураг 41.** Шилэн кабелийн интернет ашиглах боломж бүрдвэл ГЭРТЭЭ интернет ашиглах хэмжээ, хугацаа өсөх тухай төсөөлөл, өрхийн интернеттэй эсэхээр




**2.4. Интернет хэрэглэдэггүй түвшин, шалтгаан**

Өрхийн интернеттэй, интернетгүй байхаас үл хамааран гэр хорооллын өрх, өрхийн гишүүдийн хувьд интернет гэдэг өдөр тутмын зайлшгүй хэрэгцээт зүйл болсныг өмнөх бүлгүүд харуулж байна. Эсрэгээрээ интернет хэрэглэдэггүй түвшин маш бага гэж ойлгох хэрэгтэй бөгөөд хэдийгээр бага хэдий ч хэрэглээний төвшин, хэрэглэдэггүй шалтгааныг тодруулсан цөөн асуултын үр дүнг дор харуулав.


Өрхийн гишүүн бүрээс тодруулсан асуултын үр дүнгээр 0-9 насны хүүхэд болон 55-аас дээш насны хүмүүсийн хувьд интернет хэрэглэдэггүй төвшин бусад бүлгүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байгааг харж болохоор байна.

**Зураг 42.** Интернет хэрэглэдэггүй төвшин, өрхийн гишүүн бүрийн асуултын үр дүн



Судалгааны асуулга бөглөсөн буюу судалгааны үндсэн оролцогчдоос интернет хэрэглэдэг эсэхийг нь тодруулсан асуултын үр дүнг дор харуулав. Үр дүнгээс харахад интернет хэрэглэдэггүй төвшин ердөө 13.4% байгаа бөгөөд цаашид ч буурах хандлага байгаа гэж үзэж болно. Үүнийг өрхийн гишүүн бүрээс асуусан асуултын үр дүнгээр жишээ болгон тайлбарлав. 45-54 насны бүлэг 10 жилийн дараа гэхэд 55+ насны бүлэгт шилжих бөгөөд интернет нь нэгэнт өдөр тутмын хэрэглээ болчихсон нөхцөлд 10 жилийн дараа ч хэрэглэсээр байх магадлал өндөр юм. Тэгэхээр 10 жилийн дараа гэхэд 55-64 насны бүлгийн хэрэглэдэггүй төвшин 22.6% биш 10%-руу буурна гэж төсөөлж болно.

**Зураг 43.** Судалгаанд оролцогчдын интернет хэрэглэдэггүй төвшин



Интернет ашигладаггүй бүлэг хэдийгээр маш цөөн хэдий ч интернет ашигладаггүй шалтгааныг тодруулсан асуултын үр дүнг дор харуулав. Интернет ашигладаггүй оролцогчдын 38.4% нь хэрхэн ашиглахаа мэддэггүй гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл эдгээр хүмүүсийн хувьд сурчихвал ашиглах боломжтой гэж үзэж буйн илрэл юм. Тэгвэл интернет ашиглах шаардлагагүй гэж боддог үзүүлэлт интернет ашигладаггүй хүмүүсийн ердөө 23.1% байна. Өөрөөр хэлбэл интернет ашиглах боломж бүрдэх, интернет ашиглаад сурчихвал интернет хэрэглээ цаашид өсөх хандлага байгааг энэ үзүүлэлт харуулж байна.

**Зураг 44.** Интернет хэрэглэдэггүй шалтгаан, ашигладаггүй бол 100%




## Гурав. ӨРХИЙН ИНТЕРНЕТ ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

Энэ бүлгээр өрхийн интернеттэй оролцогчдын үйлчилгээ үзүүлэгч компанидаа хэр сэтгэл ханамжтай байгааг сэтгэл ханамжид нөлөөлж болох хүчин зүйл тус бүрийн хувьд үнэлүүлсэн үр дүнг харуулахаас гадна шилэн кабелийн суурин интернетийн төлөөлөл болох Юнивишн, хөдөлгөөнт интернетийн төлөөлөл болох ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээг ашигладаг оролцогчдын хувьд сэтгэл ханамжийн харьцуулсан үр дүнг мөн харуулна.


### 3.1. Сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйл, тэдгээрийн үнэлгээ, харьцуулалт

Өрхийн интернетийн хамгийн чухал үзүүлэлт юу вэ гэсэн асуултад хурд, үнэ болон датаны хэмжээ гэж хамгийн их хариулжээ. Эдгээр хүчин зүйлсийн үзүүлэлт бусад хүчин зүйлсээс 2-3 дахин их байна. Өөрөөр хэлбэл хурд сайн, үнэ боломжийн, дата хэмжээ хангалттай их байхад сэтгэл ханамж өндөр байх магадлалтай болохыг эндээс харж болно. Өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй оролцогчдын хувьд харьцуулан харахад ТОП5 сонголт адилхан буюу үзүүлэлтийн хувьд ойролцоо байгаа нь өрхийн интернеттэй байхаас үл хамаарах хурд, үнэ, дата хэмжээ гэдэг сэтгэл ханамжид нөлөөлж болох хамгийн чухал хүчин зүйлс гэдгийг дахин баталж байна.


**Зураг 45.** Өрхийн интернетийн хамгийн чухал 5 үзүүлэлт



**Зураг 46.** Өрхийн интернетийн хамгийн чухал 5 үзүүлэлт, өрхийн интернеттэй оролцогчийн хувьд



**Зураг 47.** Өрхийн интернетийн хамгийн чухал 5 үзүүлэлт, өрхийн интернетгүй оролцогчийн хувьд



**Хүснэгт 8. Өрхийн интернетийн хамгийн чухал үзүүлэлтүүд**

#	Хүчин зүйлс	ҮР ДҮН	#	Хүчин зүйлс	ҮР ДҮН
1	Хурд	82.1%	9	Файл, материал илгээхэд тасалдал, гацалтгүй байдал	15.7%
2	Үнэ	73.7%	10	Видео, аудио дуудлага хийхэд тасалдал гацалтгүй байдал	13.1%
3	Датаны хэмжээ	64.2%	11	Гар утасны яриа, интернет нэг багц үйлчилгээ	10.2%
4	Видео, аудио дуудлага хийхэд тасалдал гацалтгүй байдал	29.8%	12	Гэмтэл саатлыг шийдсэн байдал	8.7%
5	Урамшуулал	29.6%	13	Засвар үйлчилгээний шуурхай байдал	8.6%
6	Ачаалалтай цаг буюу 6-9 цагийн хооронд интернетийн тасалдал, гацалтгүй байдал	17.7%	14	Тухайлан нэг вэбсайт, платформ дээр тасалдал гацалт үүсдэг байдал. Жишээлбэл: Look TV, VOO, Netflix	5.8%
7	Сүлжээний чанар, бэлэн байдал (гэмтэл саатал, тасалдал гэх мэт)	17.1%	15	Лавлах утсаар авах тусламж үйлчилгээ	2.6%
8	Нэмэлт үйлчилгээ	16.7%	16	Үйлчилгээний ажилтны харилцаа	1.9%

Үнэ, хурд болон датаны хэмжээ сэтгэл ханамжид нөлөөлж болохуйц хамгийн чухал үзүүлэлт гэж өмнө дурдсан. Тэгвэл өрхийн интернеттэй өрхүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээнээс харахад эерэг буюу сэтгэл ханамжтай гэж хариулсан хувиар үнэ, дата хэмжээ, хурд тэргүүлж байна. Өөрөөр хэлбэл хамгийн чухал хүчин зүйлс болон хамгийн өндөр сэтгэл ханамжтай хүчин зүйлс хоорондоо нийцэж байгаа учраа ерөнхий дүнгээрээ өрхийн интернетдээ сэтгэл ханамж өндөр гэж дүгнэж болохоор байна.

Харин сэтгэл ханамжийн сөрөг үнэлгээгээр оргил ачаалалтай цагийн гацалт болон бусад төрлийн тасалдлууд тэргүүлж байна. Дээрх үр дүнгүүдийг багцлаад үзэхэд гацалт, тасалдлын асуудлууд шийдэгдвэл сэтгэл ханамжийн төвшин өндөр байх боломжтой гэж үзэж болохоор байна.

Сэтгэл ханамжийн дундаж оноог тооцож үзэхэд хамгийн багадаа 3.28, хамгийн ихдээ 3.64 буюу 16 хүчин зүйлсийн сэтгэл ханамжийн оноо маш ойролцоо гарсан. Оролцогчийн хувьд хамгийн багадаа 1 оноо, хамгийн ихдээ 5 оноо өгөх боломжтой бөгөөд 3.28-аас 3.64-ийн хооронд гэдэг нь сэтгэл ханамжийн төвшин дунд болон дундаас дээгүүр төвшинд байна гэж үзэж болохоор байна.


**Зураг 48. Сэтгэл ханамжийн ЭЕРЭГ үнэлгээний нийлбэрээр тэргүүлэгч 5 хүчин зүйлс (5 болон 4 хариултын нийлбэр)**

1	Үнэ	56.7%
2	Датаны хэмжээ	52.6%
3	Хурд	52.1%
4	Видео үзэхэд тасалдал, гацалтгүй байдал	49.4%
5	Видео, аудио дуудлага хийхэд тасалдал, гацалтгүй байдал	47.7%


**Зураг 49. Сэтгэл ханамжийн ЭЕРЭГ үнэлгээний нийлбэрээр хамгийн бага 5 хүчин зүйлс (5 болон 4 хариултын нийлбэр)**

16	Гар утасны яриа, интернет нэг багц үйлчилгээ	32.2%
15	Нэмэлт үйлчилгээ	32.7%
14	Урамшуулал	34.7%
13	Гэмтэл саатлыг шийдсэн байдал	35.4%
12	Засвар үйлчилгээний шуурхай байдал	36.8%

**Зураг 50.** Сэтгэл ханамжийн СӨРӨГ үнэлгээний нийлбэрээр тэргүүлэгч 5 хүчин зүйлс (2 болон 1 хариултын нийлбэр)



**Зураг 51.** Сэтгэл ханамжийн СӨРӨГ үнэлгээний нийлбэрээр хамгийн бага 5 хүчин зүйлс (2 болон 1 хариултын нийлбэр)



Сэтгэл ханамжийн оноог тооцоход дараах томъёог ашигласан.


Сэтгэл ханамжтай			Сэтгэл ханамжгүй	
5	4	3	2	1
5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо

$$Score = \frac{5 * \text{Давтамж}(5) + 4 * \text{Давтамж}(4) + 3 * \text{Давтамж}(3) + 2 * \text{Давтамж}(2) + 1 * \text{Давтамж}(1)}{\text{Давтамж}(1, 2, 3, 4, 5 \text{ гэсэн хариултын нийт давтамж})}$$

**Зураг 52.** Сэтгэл ханамжийн ОНОО, тэргүүлэгч 5 хүчин зүйл, тооцоолсон утга



**Зураг 53.** Сэтгэл ханамжийн ОНОО, хамгийн бага 5 хүчин зүйл, тооцоолсон утга



**Хүснэгт 9. Өрхийн интернеттэй өрхүүдийн хүчин зүйлс тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ**

	Хүчин зүйлс	Сэтгэл ханамжтай			Сэтгэл ханамжгүй		Мэдэхгүй	НИЙТ
		5	4	3	2	1		
1	Үнэ	25.5%	31.2%	21.5%	12.6%	4.5%	4.8%	100.0%
2	Хурд	24.5%	27.6%	22.5%	15.1%	6.4%	3.9%	100.0%
3	Датаны хэмжээ	23.6%	29.0%	21.6%	15.5%	5.3%	5.0%	100.0%
4	Видео үзэхэд тасалдал, гацалтгүй байдал	21.9%	27.5%	22.0%	15.7%	6.0%	6.9%	100.0%
5	Файл, материал илгээхэд тасалдал, гацалтгүй байдал	19.8%	26.8%	20.0%	15.3%	5.3%	12.8%	100.0%
6	Видео, аудио дуудлага хийхэд тасалдал гацалтгүй байдал	19.2%	28.5%	19.8%	14.9%	6.0%	11.4%	100.0%
7	Тухайлан нэг вэбсайт, платформ дээр тасалдал гацалт үүсдэг байдал. Жишээлбэл: Look TV, VOO, Netflix	18.0%	26.5%	19.7%	14.8%	7.0%	13.9%	100.0%
8	Ачаалалтай цаг буюу 6-9 цагийн хооронд интернетийн тасалдал, гацалтгүй байдал	19.6%	24.0%	21.9%	14.7%	8.2%	11.7%	100.0%
9	Сүлжээний чанар, бэлэн байдал (гэмтэл саатал, тасалдал гэх мэт)	17.8%	24.2%	20.4%	14.9%	5.4%	17.2%	100.0%
10	Засвар үйлчилгээний шуурхай байдал	16.1%	20.7%	18.7%	13.4%	4.4%	26.6%	100.0%
11	Гэмтэл саатлыг шийдсэн байдал	14.6%	20.9%	18.2%	13.3%	3.4%	29.6%	100.0%
12	Лавлах утсаар авах тусламж үйлчилгээ	16.6%	22.9%	15.5%	12.7%	3.3%	29.1%	100.0%
13	Үйлчилгээний ажилтны харилцаа	18.1%	24.6%	14.3%	12.7%	3.5%	26.8%	100.0%
14	Урамшуулал	15.1%	19.6%	18.1%	14.6%	7.0%	25.6%	100.0%
15	Нэмэлт үйлчилгээ	14.6%	18.1%	18.7%	12.9%	7.3%	28.4%	100.0%
16	Гар утасны яриа, интернет нэг багц үйлчилгээ	14.2%	18.0%	16.3%	12.4%	6.2%	32.9%	100.0%

**3.2. Зарим гол нийлүүлэгч тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ, харьцуулалт**

Одоогоор өрхүүдийн дийлэнх нь 4G хөдөлгөөнт интернет ашиглах боломжтой байгаа бөгөөд тодорхой хэсэгт нь шилэн кабелийн суурин интернетийн дэд бүтэц шийдэгдэж, Юнивишн компанийн үйлчилгээг авах болсныг өмнөх бүлгүүдээр харуулсан. Тэгвэл 4G хөдөлгөөнт интернетийн гол төлөөлөгч ГЭР ИНТЕРНЕТ болон шилэн кабелийн суурин интернетийн гол төлөөлөгч ЮНИВИШН компаниудын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг тус бүрд нь харуулахаас гадна харьцуулсан байдлаар энэ бүлэгт харууллаа.

**3.2.1. Юнивишн үйлчилгээ авдаг өрхүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээ**


Гэр хорооллын Юнивишн хэрэглэгчдийн сэтгэл ханамж маш өндөр байна. Өмнөх бүлгээр өрхийн интернеттэй айлуудын сэтгэл ханамжийн үнэлгээг харахад сэтгэл ханамжийн эерэг үнэлгээ хамгийн өндөртөө 56% орчим байсан бол Юнивишн хэрэглэгчдийн хувьд эерэг үнэлгээ хамгийн багадаа 58.3% байна. Өөрөөр хэлбэл ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээг боломжийн өндөр төвшинд гарахад Юнивишний нөлөө байсныг эндээс харж болно.

Эерэг үнэлгээгээр тэргүүлсэн 5 хүчин зүйлсийн үр дүнгээс харахад Юнивишн хэрэглэгч 5 оролцогч тутмын 4 нь сэтгэл ханамжтай гэсэн үр дүн харагдаж байна. Эерэг үнэлгээгээр тэргүүлэгч хүчин зүйлсийн дотор хурд, дата хэмжээнээс гадна гацалтгүй, тасалдалгүй байдлын хүчин зүйлс орж ирсэн нь сайн үзүүлэлт болж байна.


Сөрөг үнэлгээгээр тэргүүлэгч хүчин зүйлсийг үнэ тэргүүлж байна. Өмнөх бүлгээр харуулсан ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээгээр эерэг үзүүлэлтийг тэргүүлж байсан ч Юнивишн хэрэглэгчдийн хувьд сөрөг үнэлгээг тэргүүлж байна. Гэхдээ үр дүнг нарийвчилж харахад 10% гэдэг төдийлөн өндөр үзүүлэлт биш бөгөөд сэтгэл ханамжийн үнэлгээнд нөлөөлөхүйц биш байна. Энэхүү дүгнэлт фокус бүлгийн агуулгад илүү тод илэрсэн үнэлэмж болно.

Сэтгэл ханамжийн дундаж оноог тооцож үзэхэд 4.04-өөс 4.44 хүртэл үнэлсэн байгаа нь сэтгэл ханамжийн үнэлгээний хувьд маш өндөр үзүүлэлт юм.


**Зураг 54. Юнивишн, ЭЕРЭГ үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс**



**Зураг 55. Юнивишн, ЭЕРЭГ үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс**



**Зураг 56. Юнивишн, СӨРӨГ үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс**




**Зураг 57. Юнивишн, СӨРӨГ үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс**



Сэтгэл ханамжийн дундаж оноо тооцох томьёо:

$$Score = \frac{5 * \text{Давтамж}(5) + 4 * \text{Давтамж}(4) + 3 * \text{Давтамж}(3) + 2 * \text{Давтамж}(2) + 1 * \text{Давтамж}(1)}{\text{Давтамж}(1, 2, 3, 4, 5 \text{ гэсэн хариултын нийт давтамж})}$$

**Зураг 58. Юнивишн, сэтгэл ханамжийн оноо, хамгийн өндөр 5 хүчин зүйлс**



**Зураг 59. Юнивишн, сэтгэл ханамжийн оноо, хамгийн бага 5 хүчин зүйлс**



**Хүснэгт 10. ЮНИВИШН үйлчилгээг авдаг өрхүүдийн хүчин зүйлс тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ**

	Хүчин зүйлс	Сэтгэл ханамжтай			Сэтгэл ханамжгүй		Мэдэхгүй	НИЙТ
		5	4	3	2	1		
1	Үнэ	48.2%	26.1%	10.1%	4.1%	6.4%	5.0%	100.0%
2	Хурд	55.5%	27.5%	9.2%	1.4%	2.8%	3.7%	100.0%
3	Датаны хэмжээ	54.6%	28.0%	8.7%	3.2%	0.9%	4.6%	100.0%
4	Видео үзэхэд тасалдал, гацалтгүй байдал	54.1%	31.7%	6.9%	1.4%	0.9%	5.0%	100.0%
5	Файл, материал илгээхэд тасалдал, гацалтгүй байдал	49.5%	28.9%	7.3%	1.4%	1.8%	11.0%	100.0%
6	Видео, аудио дуудлага хийхэд тасалдал гацалтгүй байдал	48.6%	32.6%	6.4%	1.4%	1.8%	9.2%	100.0%
7	Тухайлан нэг вэбсайт, платформ дээр тасалдал гацалт үүсдэг байдал. Жишээлбэл: Look TV, VOO, Netflix	46.8%	29.4%	7.8%	2.3%	1.8%	11.9%	100.0%
8	Ачаалатай цаг буюу 6-9 цагийн хооронд интернетийн тасалдал, гацалтгүй байдал	49.5%	28.4%	6.0%	2.3%	1.8%	11.9%	100.0%
9	Сүлжээний чанар, бэлэн байдал (гэмтэл саатал, тасалдал гэх мэт)	46.8%	28.0%	7.8%	1.4%	1.4%	14.7%	100.0%
10	Засвар үйлчилгээний шуурхай байдал	41.7%	22.0%	12.8%	0.9%	0.9%	21.6%	100.0%
11	Гэмтэл саатлыг шийдсэн байдал	39.0%	25.2%	11.0%	2.3%	0.0%	22.5%	100.0%
12	Лавлах утсаар авах тусламж үйлчилгээ	39.9%	27.5%	7.3%	3.2%	1.4%	20.6%	100.0%
13	Үйлчилгээний ажилтны харилцаа	39.9%	28.9%	7.8%	1.4%	1.4%	20.6%	100.0%
14	Урамшуулал	37.2%	25.2%	12.8%	4.6%	3.2%	17.0%	100.0%
15	Нэмэлт үйлчилгээ	38.1%	24.3%	11.9%	3.2%	3.2%	19.3%	100.0%
16	Гар утасны яриа, интернет нэг багц үйлчилгээ	34.9%	23.4%	11.0%	3.2%	2.8%	24.8%	100.0%

**3.2.2. ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээг авдаг өрхүүдийн сэтгэл ханамжийн үнэлгээ**

Гэр хорооллын ГЭР ИНТЕРНЕТ хэрэглэгчдийн сэтгэл ханамж хангалттай хэмжээнд сайн биш гэж харж болохоор байна. Эерэг үнэлгээний нийлбэрийг үнэ, хурд болон дата хэмжээ тэргүүлж байгаа ч үр дүнгийн хувьд 50% ч хүрэхгүй байгаа нь хангалттай үзүүлэлт биш юм. Энэ нь чанарын судалгааны агуулгад маш тод илэрсэн агуулга бөгөөд сэтгэл ханамжгүй байгаа шалтгаануудыг нарийвчлан нэрлэснийг фокус бүлгийн бүлгийн транскрипшаас дэлгэрүүлэн харах боломжтой.

Хурд болон дата хэмжээ нь эерэг үнэлгээгээр тэргүүлэгч хүчин зүйлсийн дотор багтаж байгаа ч мөн сөрөг үнэлгээгээр тэргүүлж хүчин зүйлсийн дотор мөн багтжээ. Сөрөг үнэлгээгээр тэргүүлж хүчин зүйлсийн дотор хурд, гацалтгүй болон тасалдалгүй байдал гэсэн агуулга ойролцоо 4 хүчин зүйлс багтсан байгаа нь илүү хурдан, гацалтгүй, тасалдалгүй интернетийн хэрэгцээ байгааг харж болохоор байна.



**Зураг 60. ГЭР ИНТЕРНЕТ, Эерэг үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс**

1	Үнэ	46.5%
2	Хурд	35.4%
3	Датаны хэмжээ	33.5%
4	Үйлчилгээний ажилтны харилцаа	31.7%
5	Видео үзэхэд тасалдал, гацалтгүй байдал	31.4%

**Зураг 61. ГЭР ИНТЕРНЕТ, Эерэг үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс**

16	Нэмэлт үйлчилгээ	18.8%
15	Гар утасны яриа, интернэт нэг багц...	20.0%
14	Урамшуулал	23.1%
13	Гэмтэл саатлыг шийдсэн байдал	24.0%
12	Засвар үйлчилгээний шуурхай байдал	24.6%

**Зураг 62. ГЭР ИНТЕРНЕТ, Сөрөг үнэлгээ, хамгийн их 5 хүчин зүйлс**

1	Хурд	33.2%
2	Ачаалалтай цаг буюу 6-9 цагийн хооронд интернэтийн тасалдал, гацалтгүй байдал	32.6%
3	Видео үзэхэд тасалдал, гацалтгүй байдал	32.3%
4	Датаны хэмжээ	32.3%
5	Видео, аудио дуудлага хийхэд тасалдал, гацалтгүй байдал	31.4%

**Зураг 63. ГЭР ИНТЕРНЕТ, Сөрөг үнэлгээ, хамгийн бага 5 хүчин зүйлс**



16	Лавлах утсаар авах тусламж үйлчилгээ	21.5%
15	Үнэ	22.2%
14	Үйлчилгээний ажилтны харилцаа	22.8%
13	Гэмтэл саатлыг шийдсэн байдал	23.4%
12	Засвар үйлчилгээний шуурхай байдал	24.3%

Сэтгэл ханамжийн үнэлгээг дундаж оноогоор илэрхийлсэн бөгөөд оноогоор илэрхийлэхдээ дараах томъёог ашигласан.

Сэтгэл ханамжтай			Сэтгэл ханамжгүй	
5	4	3	2	1
5 оноо	4 оноо	3 оноо	2 оноо	1 оноо

$$Score = \frac{5 * \text{Давтамж}(5) + 4 * \text{Давтамж}(4) + 3 * \text{Давтамж}(3) + 2 * \text{Давтамж}(2) + 1 * \text{Давтамж}(1)}{\text{Давтамж}(1, 2, 3, 4, 5 \text{ гэсэн хариултын нийт давтамж})}$$

Сэтгэл ханамжийн онооны үр дүнгээс харахад ГЭР ИНТЕРНЕТ хэрэглэгчид ихэнх хүчин зүйлсийг дунд болон түүнээс доогуур үнэлсэн байна.

**Зураг 64. ГЭР ИНТЕРНЕТ, сэтгэл ханамжийн оноо, хамгийн өндөр 5 хүчин зүйлс****Зураг 65. ГЭР ИНТЕРНЕТ, сэтгэл ханамжийн оноо, хамгийн бага 5 хүчин зүйлс****Хүснэгт 11. ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээг авдаг өрхүүдийн хүчин зүйлс тус бүрийн сэтгэл ханамжийн үнэлгээ**

Ранг	Хүчин зүйлс	Сэтгэл ханамжтай			Сэтгэл ханамжгүй		Мэдэхгүй	НИЙТ
		5	4	3	2	1		
1	Үнэ	14.2%	32.3%	28.0%	18.5%	3.7%	3.4%	100.0%
2	Хурд	8.9%	26.5%	28.3%	24.6%	8.6%	3.1%	100.0%
3	Датаны хэмжээ	7.4%	26.2%	29.5%	25.2%	7.1%	4.6%	100.0%
4	Видео үзэхэд тасалдал, гацалтгүй байдал	7.1%	24.3%	29.2%	24.3%	8.0%	7.1%	100.0%
5	Файл, материал илгээхэд тасалдал, гацалтгүй байдал	7.1%	24.3%	27.1%	22.8%	6.2%	12.6%	100.0%
6	Видео, аудио дуудлага хийхэд тасалдал гацалтгүй байдал	5.8%	24.9%	25.5%	22.5%	8.9%	12.3%	100.0%
7	Тухайлан нэг вэбсайт, платформ дээр тасалдал гацалт үүсдэг байдал. Жишээлбэл: Look TV, VOO, Netflix	4.6%	24.3%	25.8%	20.3%	10.2%	14.8%	100.0%
8	Ачаалалтай цаг буюу 6-9 цагийн хооронд интернэтийн тасалдал, гацалтгүй байдал	6.5%	20.0%	28.6%	20.9%	11.7%	12.3%	100.0%
9	Сүлжээний чанар, бэлэн байдал (гэмтэл саатал, тасалдал гэх мэт)	5.5%	21.8%	24.6%	22.5%	6.8%	18.8%	100.0%
10	Засвар үйлчилгээний шуурхай байдал	6.8%	17.8%	21.8%	18.2%	6.2%	29.2%	100.0%
11	Гэмтэл саатлыг шийдсэн байдал	5.5%	18.5%	20.9%	18.2%	5.2%	31.7%	100.0%
12	Лавлах утсаар авах тусламж үйлчилгээ	5.8%	20.6%	18.8%	16.9%	4.6%	33.2%	100.0%
13	Үйлчилгээний ажилтны харилцаа	8.3%	23.4%	15.4%	19.1%	3.7%	30.2%	100.0%
14	Урамшуулал	6.2%	16.9%	21.2%	19.7%	8.0%	28.0%	100.0%
15	Нэмэлт үйлчилгээ	4.6%	14.2%	23.4%	17.5%	9.5%	30.8%	100.0%
16	Гар утасны яриа, интернет нэг багц үйлчилгээ	5.8%	14.2%	19.4%	16.9%	7.7%	36.0%	100.0%

### 3.2.3. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт

Шилэн кабелийн суурин интернэтийн төлөөлөл Юнивишн гэр хороолол руу хурдацтай нэвтэрч эхэлсэн нь суурин интернет болон хөдөлгөөнт интернэтийн сэтгэл ханамжийг харьцуулах боломж олголоо. Хөдөлгөөнт интернэтийн хамгийн гол төлөөлөл болох ГЭР ИНТЕРНЕТ болон


суурин интернетийн одоогоор ганц төлөөлөл болох ЮНИВИШН хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг харьцуулсан байдлаар энэ бүлэгт харууллаа.

Бидний сонгосон 16 хүчин зүйлс тус бүрийн эерэг хариултын нийлбэрээр ЮНИВИШН хэрэглэгчид, ГЭР ИНТЕРНЕТ хэрэглэгчдээс бараг 2-3 дахин илүү үнэлсэн. Эсрэгээрээ сөрөг хариултын нийлбэрээр 5-10 дахин бага үнэлсэн байна. Өөрөөр хэлбэл шилэн кабелийн суурин интернет хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамж маш өндөр, хөдөлгөөнт интернет хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамж дунд ба түүнээс доош гэж харж болохоор байна. Энэхүү үр дүнгээс хөдөлгөөнт интернет өрхийн интернет хэрэглээг тодорхой хэмжээнд хангаж байгаа ч хангалттай сайн хэмжээнд биш гэдэг тодорхой байна. Өөрөөр хэлбэл шилэн кабелийн суурин интернетийг орлохуйц хэмжээнд байж чадахгүй байна гэж үзэж болохоор байна. Эндээс үзэхэд гэр хороолол руу шилэн кабел татах, суурин интернет ашиглах боломж бүрдүүлэх зайлшгүй шаардлага байгаа нь тодорхой харагдаж байна.

Бидний сонгосон 16 хүчин зүйлс тус бүрийн үр дүн дор харуулсан бөгөөд жишээ болгон “үнэ” дээр тайлбарлана.


Юнивишний хувьд сөрөг хариултын нийлбэр 10.6% байсан нь бусад хүчин зүйлстэй харьцуулахад хамгийн их сөрөг хариулт байсан. Гэтэл ГЭР ИНТЕРНЕТ хэрэглэгчдийн хувьд сөрөг хариултын нийлбэр 22.2% буюу Юнивишнтэй харьцуулахад 2 дахин их байгаа ч бусад хүчин зүйлсийн сөрөг хариулттай харьцуулахад харьцангуй бага байсан. Зөвхөн энэ үр дүнгээс л харахад ЮНИВИШН болон ГЭР ИНТЕРНЕТ хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн зөрүү өндөр төвшинд байгаа нь ойлгомжтой байна.

**Зураг 66.** Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 01




**Зураг 67.** Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 02






Зураг 68. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 03




Зураг 69. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 04




Зураг 70. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 05






Зураг 71. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 06




Зураг 72. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 07




Зураг 73. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 08






Зураг 74. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 09




Зураг 75. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 10




Зураг 76. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 11






Зураг 77. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 12




Зураг 78. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 13




Зураг 79. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 14






Зураг 80. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 15



Зураг 81. Сэтгэл ханамжийн үнэлгээний харьцуулалт - 16




### Дөрөв. ЦАХИМ ХИЧЭЭЛИЙН ХАМРАГДАЛТЫН ТУХАЙ


2020-2021 онд Ковид19 вирусийн тархалттай холбоотойгоор тогтоосон хөл хорионы улмаас бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалт цахимд шилжсэн. Энэ үеэр ерөнхий боловсролын сургуулийн сурагчид цахим сургалтад хамрагдсан эсэх талаар тодруулсан үр дүнг энэ бүлгээр харуулна.




**Зураг 82.** Сургуулийн насны хүүхэдтэй эсэх




**Зураг 83.** Цахим сургалтад хамрагдсан эсэх, сургуулийн насны хүүхэдтэй бол 100%



**Зураг 84.** Цахим сургалтад хамрагдсан хэлбэр, хамрагдсан бол 100%




**Зураг 85.** Цахим сургалтад хамрагдаагүй шалтгаан, хамрагдаагүй бол 100%




2020-2021 онд Ковид19 вирусийн тархалттай холбоотойгоор цахим хичээл орох болсонтой холбоотойгоор интернэт хэрэглэгчдийн тоо өссөнөөс гадна чанарын судалгаанд оролцогчдын дийлэнх хувийн интернэт хэрэглэх шалтгаант үзүүлэлтэд цахим хичээл өндөр үзүүлэлттэй байсан.

**Тав. ХҮН АМЗҮЙН МЭДЭЭЛЭЛ**


**Зураг 86.** Судалгаанд оролцогчдын ам бүлийн тоо




Зураг 87. Судалгаанд оролцогчдын насны бүлэг



Зураг 88. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа



Зураг 89. Судалгаанд оролцогчдын боловсрол



Зураг 90. Судалгаанд оролцогчдын ажил эрхэлдэг эсэх



Хүснэгт 12. Ажил хийдэг бол

#	Хариулт	ХУВЬ
1	Төсвийн байгууллагад ажилладаг	15.6%
2	Төрийн бус байгууллагад ажилладаг	3.1%
3	Хувийн байгууллагад ажилладаг (өөрийн биш)	26.2%
4	Хувиараа бизнес эрхэлдэг	12.6%
5	Бусад	0.3%
6	Татгалзсан	1.1%
	<b>АЖИЛ ХИЙДЭГГҮЙ</b>	<b>41.2%</b>
#	<b>НИЙТ</b>	<b>100.0%</b>

Хүснэгт 13. Ажил хийдэггүй бол

#	Хариулт	ХУВЬ
1	Тэтгэвэрт	13.4%
2	Эрүүл мэндийн шалтгаанаар / группэд	3.0%
3	Оюутан	7.7%
4	Гэр орны ажилтай / хүүхэд хардаг	10.0%
5	Заримдаа ажилгүй / улирлын шинжтэй ажилладаг	0.9%
6	Огт ажилгүй	1.2%
7	Бусад	1.5%
8	Мэдэхгүй / Хариулахаас татгалзсан	3.4%
	<b>АЖИЛ ХИЙДЭГ</b>	<b>58.8%</b>
#	<b>НИЙТ</b>	<b>100.0%</b>

## ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын гэр хорооллын өрх, өрхийн гишүүдийн интернет хэрэглээ болон сэтгэл ханамжийн үнэлэх зорилгын хүрээнд өрхийн интернеттэй 800, өрхийн интернетгүй 800 өрхийг хамруулсан судалгаа хийж гүйцэтгэлээ. Судалгааны үр дүнд үндэслэн **ТООН СУДАЛГАА**-ны голлох дүгнэлтийг энд тусгаж байна.

Өрхийн интернет холболт, харилцаа холбооны зардал болон бусад үзүүлэлтийн тухайд:

- ❖ Судалгаанд хамрагдсан өрхийн интернеттэй айлуудын 40.8% хувь ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээг ашиглаж байсан нь Улаанбаатар хотын гэр хорооллын хамгийн өргөн тархсан интернет үйлчилгээ байсан.
- ❖ Сүүлийн 1-2 жилийн хугацаанд Юнивишн компанийн үйлчилгээ гэр хороололруу ихээр нэвтрэх болсон бөгөөд бидний төсөөлснөөс ч илүү хурдтай, идэвхтэй нэвтэрч байгааг судалгаа үр дүн харуулсан. Нийт өрхийн интернеттэй айлуудын 27.4% нь Юнивишн үйлчилгээ ашигладаг гэж хариулсан бөгөөд энэ нь бидний төсөөлснөөс 2-3 дахин их дүн байлаа. Судалгааны дүнгээр шилэн кабелд суурилсан Юнивишн үйлчилгээний хэрэглэгчид өндөр төвшинд байсан нь сэтгэл ханамжийн үнэлгээг технологиор харьцуулах боломж олгосон.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны сарын дундаж зардал 83000 төгрөг орчим байсан. Энэхүү үр дүн нь 2022 оны эхэнд танилцуулагдсан Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Үндэсний статистикийн хорооны хамтарсан “Өрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгаа”-ны үр дүнтэй нийцэж байсан.
- ❖ Мэдээлэл, харилцаа холбооны сарын дундаж зардлыг өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй өрхүүдийн хувьд харьцуулан харахад 30000 төгрөг орчмын зөрүүтэй байсан ба энэ зөрүү нь сарын дундаж интернет хэрэглээний зардалтай яв цав нийцэж байсан.
- ❖ Өрхийн интернеттэй болон өрхийн интернетгүй өрхүүдийн сарын дундаж орлого тооцооллын дүнгээр 200000 гаруй төгрөгөөр зөрүүтэй байсан ба эндээс өрхийн интернеттэй байх эсэхэд орлогын нөлөө байна гэж дүгнэсэн.
- ❖ Өрхийн интернетэд холбогдоогүй шалтгааны хувьд “гар утасны дата ашиглаад интернет хэрэглээгээ шийдчихдэг” гэсэн хариулт 54.6% буюу хамгийн өндөр байсан. Бусад шалтгааны хувьд хамгийн ихдээ 18.1%-тай байсан.
- ❖ Харин өрхийн интернеттэй болох төлөвлөгөө байгаа эсэхэд 50.2% нь шууд тийм гэж хариулсан бол үгүй гэж ердөө 18.6% нь хариулсан. Өөрөөр хэлбэл энэхүү үр дүнгээс хэдийгээр гар утасны дата ашиглан хэрэглээгээ шийдэж байгаа ч өрхийн интернетийн хэрэгцээ байгаа нь тодорхой харагдсан.
- ❖ Шилэн кабелийн суурин интернет ашиглах боломж бүрдвэл ашиглах эсэх үнэлгээг хийлгэхэд ердөө 4.1% нь гар утасны дата хангалттай гэж хариулсан. Энэ үр дүн өмнөх дүгнэлтийг баталсан.

Интернет хэрэглээний тухайд:

- ❖ Интернет хэрэглэдэг эсэх талаар зөвхөн судалгаа бөглөсөн оролцогчдоос гадна тухайн өрхийн гишүүн бүрийн хувьд тодруулсан. Өрхийн гишүүн бүрийн хувьд тодруулсан асуултын үр дүнгээр 0-9 насны хүүхэд болон 65+ насны ахмадуудын хувьд интернет хэрэглээ харьцангуй бага бусад бүлгүүдийн хувьд 80% ба түүнээс дээш үзүүлэлттэй байсан. Өөрөөр хэлбэл интернет нь бүх насныхны өдөр тутмын байнгын хэрэглээ болсныг батлах үзүүлэлт болсон.
- ❖ Судалгаа бөглөсөн оролцогчдын хувьд 86.6% нь интернет хэрэглэдэг гэж хариулсан ба эдгээрээс 3.6%-иас бусад нь өдөр бүр интернет хэрэглэдэг гэж хариулсан. Энэхүү үр дүн интернет нь өдөр тутмын байнгын хэрэглээ болсон гэдэг дүгнэлтийг дахин баталсан.

- ❖ Өрхийн интернетгүй оролцогчдын хувьд ч интернет хэрэглээний түвшин 81.6% байсан нь өрхийн интернеттэй, интернетгүй байхаас үл хамааран ямар өргөн хэмжээнд тархсаныг тодорхой харуулсан.
- ❖ Судалгаанд оролцогчдын 44.4% буюу ойролцоогоор 2 оролцогч тутмын 1 нь өдөрт 3-аас илүү цаг интернет хэрэглэдэг гэж хариулсан. Интернет ашиглах давтамжийг насны бүлгээр харьцуулах харахад насны ахих тусам интернетэд зарцуулах хугацаа буурч байсан.
- ❖ Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 98-99% нь ажлын болон амралтын өдөр байхаас үл хамараан ГЭРТЭЭ тодорхой хэмжээнд интернет хэрэглэдэг гэж хариулсан.
- ❖ Интернет ашиглах төхөөрөмжийн хувьд хамгийн түгээмэл нь гар утас бөгөөд интернет ашиглах төрлийн хувьд мөн хамгийн түгээмэл нь гар утасны дата байсан.
- ❖ Интернет ашиглах зорилгын хувьд хамгийн түгээмэл нийгмийн сүлжээ болон бүх төрлийн чат байсан бөгөөд эдгээр мэдээлэл, харилцаа холбооны гол хэрэгслүүдийн нэг болсныг үр дүн харуулсан.
- ❖ Гар утасны дата хэрэглээ нас бүлэг тус бүр дээр маш өндөр төвшинд байсан. Бүлэг тус бүрийн интернет хэрэглэдэг оролцогчдын багадаа 87% нь гар утасны дата ашигладаг гэж хариулсан.
- ❖ Судалгаанд оролцогч интернет хэрэглэдэг хүмүүсийн 91.7% нь гар утасны дата ямар нэг байдлаар ашигладаг гэж хариулсан бөгөөд энэ үзүүлэлт өрхийн интернеттэй, интернетгүй байхаас үл хамааран өндөр төвшинд байсан.
- ❖ Судалгаанд оролцогч гар утасны дата хэрэглэдэг 3 оролцогч тутмын 2 нь сард 5GB ба түүнээс их дата хэрэглэдэг гэж хариулсан.
- ❖ Гар утасны дата хэрэглээг насны бүлгээр харьцуулах зорилгоор сард багадаа 10GB дата хэрэглэдэг бүлгийг судалж үзсэн бөгөөд нас ахих тусам тусам энэ үзүүлэлт буурч байсан. Өөрөөр хэлбэл нас ахих тусам дата хэрэглээ буурдаг гэж ойлгож болно. Өмнөх үр дүнгүүдэд нас ахих тусам интернет хэрэглэх хугацаа буурч байсныг дурдсан бөгөөд энэ үр дүнгүүд хоорондоо нийцэж байгааг харж болно.
- ❖ Судалгаанд оролцогч гар утасны дата хэрэглэдэг ойролцоогоор 2 оролцогч тутмын 1 нь нэмэлт дата авдаг гэж хариулсан бөгөөд нэмэлт дата авахад сард дунджаар 27000 орчим төгрөгийг зарцуулдаг байна. Дундаж зардлын хувьд өрхийн интернеттэй, интернетгүй байхаас үл хамааран ойролцоо төвшинд байсан. Энэ болон өмнөх бусад үр дүнгүүд өрхийн интернеттэй болсон ч гар утасны дата хэрэглээ байсаар байхыг баталсаар байна.
- ❖ Интернет огт хэрэглэдэггүй гэж судалгаанд оролцогчдын 13.4% нь хариулсан. Эдгээр оролцогчдын дийлэнх хэсгийг 55+ насны ахмадууд эзэлж байсан.
- ❖ Интернет хэрэглэдэггүй шалтгааны хувьд хэрхэн ашиглахаа мэдэхгүй гэсэн хариулт давамгайлсан бөгөөд ашиглаад сурчихвал интернет хэрэглэдэг төвшин улам өсөхийг энэхүү үзүүлэлт харуулсан.

Өрхийн интернетийн сэтгэл ханамжийн хувьд:

- ❖ Өрхийн интернетийн хамгийн чухал үзүүлэлтийн тоонд хурд, үнэ болон датаны хэмжээ багтсан. Эдгээр нь өрхийн интернеттэй, интернетгүй байхаас үл хамааран ойролцоо байсан.
- ❖ Бидний үнэлүүлсэн 16 хүчин зүйл тус бүрийн сэтгэл ханамжийн оноог тооцоход 3.28-аас 3.64-ийн хооронд буюу маш ойролцоо байсан. Хамгийн багадаа 1 оноо, хамгийн ихдээ 5 оноогоор үнэлэх боломжтой байсан бөгөөд эдгээрийг харьцуулж үзвэл сэтгэл ханамжийн үнэлгээ дунд ба дундаас дээгүүр үнэлжээ гэж дүгнэж болохоор байна.
- ❖ Хэдийгээр сэтгэл ханамжийн үнэлгээ хүчин зүйл тус бүрийн хувьд ойролцоо байсан ч үнийн хувьд сэтгэл ханамжийн дундаж оноогоор тэргүүлсэн. Өөрөөр хэлбэл үнийн хувьд өндөр биш боломжийн түвшинд байгааг харуулсан. Нөгөө талаараа өмнөх бүлэгт

дурдсанаар өрхийн интернеттэй бүлгийн хувьд интернетгүй бүлгээсээ орлого өндөр байсантай холбоотой байж болно.

- ❖ Өрхийн интернет холболтын хувьд Гэр интернет ба Юнивишн компаниуд тэргүүлж байгааг өмнө дурдсан ба эдгээр нь технологийн хувьд өөр учир сэтгэл ханамжийн үнэлгээ харьцуулах боломжийг олгосон.
- ❖ Шилэн кабелийн суурин интернет буюу төлөөлүүлж авсанаар Юнивишн компанийн хэрэглэгчдийн сэтгэл ханамж маш өндөр буюу эерэг хариултын төвшин хамгийн багадаа 58%-тай хамгийн ихдээ 80%+ байсан. Өөрөөр хэлбэл шилэн кабелийн суурин интернет хэрэглэгчдийн хүсэл, сонирхлыг хангалттай төвшинд хангаж чадаж байгаагийн илрэл гэж хэлж болно.
- ❖ 4G хөдөлгөөнт интернет буюу төлөөлүүлж авснаар ГЭР ИНТЕРНЕТ үйлчилгээний хэрэглэгчдийн сэтгэл ханамж дунд ба дундаас доогуур буюу эерэг хариултын төвшин хамгийн ихдээ 46.5%-тай хамгийн багадаа 18.8% байсан. Өөрөөр хэлбэл 4G хөдөлгөөнт интернет хэрэглэгчдийн хүсэл, сонирхлыг хангалттай төвшинд хангаж чадахгүй байгааг харуулж байна.
- ❖ Интернет хэрэглээ өдөр тутмын хэрэглээ болсон. 4G хөдөлгөөн интернет хэрэглэгчдийн сэтгэл ханамж хангалттай төвшинд биш. Харин эсрэгээрээ шилэн кабелийн суурин интернет хэрэглэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаагаас дүгнэвэл гэр хороолол руу шилэн кабел татах, өрхийн суурин интернет ашиглах боломжийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага байна гэж дүгнэж болохоор байна.

Улаанбаатар хотын гэр хорооллын өрх, өрхийн гишүүдийн интернет хэрэглээ болон сэтгэл ханамжийн үнэлэх зорилгын хүрээнд өрхийн интернеттэй, өрхийн интернетгүй 64 иргэдийг хамруулсан чанарын судалгаа болох **ФОКУС БҮЛГИЙН ЯРИЛЦЛАГА**-ны голлох дүгнэлтийг энд тусгалаа.

Өрхийн интернет холболт, харилцаа холбооны зардал болон бусад үзүүлэлтийн тухайд:

- ❖ Интернет хэрэглээ өдөр тутмын хэрэглээ болсон нь оролцогчдийн интернэт хэрэглээнээс тод харагдаж байна. Оролцогчид бүгд утаснаасаа интернэт төхөөрөмжид холбогддог, интернэт хэрэглээний дийлэнх хувийг датагаар гар утаснаасаа холбогддог. Үүн дээр нэмэлтээр гэрийн интернэт болон оффисийн wifi төхөөрөмжөөс холбогддог ба цөөн тохиолдолд гэр ажлаас гадуур үйлчилгээний байгууллагын wifi-г ашигладаг. Энэ нь насны хувьд харьцангуй өөр өөр үзүүлэлттэй байсан нь тооны судалгааны үзүүлэлттэй дүйцэж байсан.
- ❖ Интернэт холболтын төхөөрөмжийн хувьд бүгд бүгд гар утаснаасаа холбогддог. Харин цөөнгүй хэсэг нь нэмэлтээр PC, Notebook, зурагтаар холбогддог. Зурагтаа холбож кино үзэх, дуу сонсох хэлбэрээр ашигладаг бол PC болон Notebook-ийг ажлын шаардлагаар, хичээл хийх зорилгоор ашигладаг. Энэ дундаас хамгийн их ашигладаг нь гар утас бөгөөд таблетийн хэрэглээ огт бүртгэгдсэнгүй.
- ❖ Фокус ярилцлагын оролцогчдын хувьд гэр болон ажил дээрээ голчлон интернэтэд холбогддог бөгөөд чөлөөт цаг гарсан л бол интернэтэд зарцуулдаг хугацаа нь хязгааргүй гэх хариултууд зонхилж байсан. Энэ нь ажлын бус цагаар болон автобусанд, замын түгжрэлд явах үедээ интернэтэд тогтмол холбогддог байна.
- ❖ Интернэт хэрэглээний гол зорилго нь мэдээлэл авах, харилцаа холбооны хэрэгсэл, ажлын шаардлага зэрэг ерөнхий хариултуудыг өгсөн. Хариултуудыг дотор нь нарийвчилбал мэдээлэл авах нь бүх оролцогчдын хувьд фэйсбүүк, групп чат их ашигладаг. Энэ нь цаг үеийн шинжтэй мэдээлэл телевизээс ч түрүүлж хурдан шуурхай түрүүлж мэддэг, live хэлбэрийн шууд нэвтрүүлэг бүрэн дүүрэн газар дээрээс нь шууд мэдээлэл авдагаас гадна бусад олон төрлийн мэдээлэл авдаг гэсэн бол харилцаа холбооны зорилгоор ашиглаж байгаа хэлбэр нь фэйсбүүкийн олон групп чат их ашигладаг болохыг оролцогчдын ярианаас тод илэрч байна. Цэцэрлэгийн хүүхдүүдээс

эхлээд сургуулийн насны хүүхдүүд, анги бүр тусгай групп чат нээсэн, тухай бүр группээсээ мэдээллээ хуваалцдаг. Ажлын хувьд мөн адил групп чат болоод бусад хэлбэрээр зайлшгүй фэйсбүүк орчинд ажиллах нөхцөл үүсэхээс гадна багш нарын хувьд ирц бүрдүүлэхээс эхлээд сургуулийн орчин дахь мэдээллээ хуваалцах хэрэгсэл болсон. Мөн цахим эрин үе ирж байгаатай холбоотойгоор дэлхий нийтийн мэдээлэл авах, дэлхийн бусад улс орны сургуульд онлайн хэлбэрээр сурч болохоор байгаа зэрэг давуу талуудыг ч дурьджээ.

- ❖ Гар утсан дээрээ интернэт банк, фэйсбүүк, emongolia, ebarimt зэргийг түгээмэл ашигладаг бол зарим хэрэглэгчдийн хувьд Voo, Looktv, clubhouse, tik tok, gmail, zoom, Instagram, teams, youtube, twitter, viber зэргийг тогтмол ашигладаг болжээ. Зарим эцэг эхчүүдийн хувьд хүүхдүүдийнхээ хийсэн бичлэгийг хянах зориогоор tok tok апп ашигладаг бол бусад платформуудын хувьд ажлын шаардлагаар, онлайн хичээл хийх зорилгоор, чөлөөт цагаараа кино, нэвтрүүлэг үзэх зэргээр ашигладаг болохыг цөөн тохиолдолд дурьджээ. Мөн утаснаасаа онлайн худалдаа, хүргэлт хийлгэх, онлайн ажиллах, онлайн дэлгүүрээр үйлчлүүлэх зэрэг хувийн ажлуудаа хөнгөвчилж буйд сэтгэл ханамжтай байдаг байна.
- ❖ Интернэт хэрэглэгчид хэрэглээний хугацааны хувьд харилцан адилгүй. Зарим нь зөвхөн шаардлага гарсан тохиолдолд л датагаа асааж интернэт хэрэглэдэг бол зарим оролцогчдын хувьд байнга асаалттай, хязгааргүй хэрэглээтэй. Интернэтэд зарцуулдаг хугацааг нь дунджаар тооцвол 4-5 цагийг тогтмол зарцуулдаг болох нь интернэтийн хэрэглээ өдөр тутмын зайлшгүй хэрэглээ болсныг бүгд хэлж байна.
- ❖ Дата хэрэглээний чухал үзүүлэлтэд хурд, дата хэмжээг онцолсон. Оролцогч бүр нэмэлтээр сардаа 1-3 удаа дата авдаг. Дата хэрэглээнд нэмэлтээр зарцуулж буй дундаж үнэлгээ 8000-30000 төгрөг. Мобиком, Юнителийн хэрэглэгчдийн хувьд харьцуулалт их байгаа бөгөөд юнителийн хэрэглэгчид дата хэрэглээндээ сэтгэл дундуур үнэлэмжтэй.
- ❖ Санхүүгийн асуудал нь интернэт хэрэглээг хязгаарлах шалтгаан нь болохгүй. Нэгэнт хэрэглээд сурчихсан хэрэглээгээ багасгах боломжгүй гэсэн нь цаашид ч интернэтийн хэрэглээ өссөөр байх хандлагатайг харуулж байна.

Өрхийн интернет хэрэглээний тухайд:

- ❖ Гэр хороололд өрхийн интернэтийн үйлчилгээ хэрэглэгчид нийт фокуст оролцогчдын 60-аас дээш хувийг эзэлж байна. Энэ нь шилэн кабелийн ЮНИВИШН, хөдөлгөөнт интернэт ГЭР ИНТЕРНЭТ төхөөрөмжийг голчлон хэрэглэж байна. Сүүлийн 1-2 жилд гэр хороололд шилэн кабелийн үйлчилгээ орсноор иргэдийн дунд ч эрэлт хэрэгцээтэй байгаа нь үүнээс харагдаж байна. Шилэн кабель нэвтрээгүй бүсэд Home media, Кевико зэрэг агаарын интернэтийн үйлчилгээг цөөнгүй хэсэг нь ашиглаж байна.
- ❖ Өрхийн интернэт нийт интернэт хэрэглээнийх нь 50%-ийг хангаж чаддаг гэж гэртээ интернэттэй хэрэглэгчид тодорхойлсон. Гэртээ өрхийн интернэттэй байхын давуу тал нь хүүхдүүдийн хувьд онлайн хичээл хийх, ажлаа амжуулах, цаг үетэйгээ хөл нийлүүлэх зэрэг олон давуу талыг дурьдахын зэрэгцээ сөрөг муу талуудыг ч нэрлэсэн. Үүнд: гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж амьд харилцаа байхгүй, гэр доторх халуун дулаан уур амьсгал байхгүй, хүүхдүүд хичээл номоо цалгардуулж тоглоомонд донтох, гэрийн ажил цалгардах зэрэг бэрхшээлүүдийг нэрлэсэн.
- ❖ Өрхийн хэрэглээний сарын зардлын хувьд Юнивишн хэрэглэгчдийн хувьд багцаасаа хамаараад тогтмол зардалтай бол хөдөлгөөнт ГЭР ИНТЕРНЭТ хэрэглэгчийн хувьд сарын хэрэглээ нь үндсэн төлбөр дээр нэмэлтээр 1-3 удаа нэмэлт дата зарцуулж өрхийн сарын хэрэглээгээ хангадаг. Энэ нь ойролцоогоор 25-43 мянган төгрөг болж байна.
- ❖ Шилэн кабель шинээр тавигдаж буй бүсчлэлд өрхийн интернэтийн үйлчилгээг сонирхож буй хэрэглэгчдийн эрэлт их байгаа ч харьцуулалт хийх боломжит үйлчилгээ эрхлэгчид

ховор байгаад шүүмжлэлттэй байсан. Эндээс шилэн кабелийн үйлчилгээ хаана ч өндөр эрэлт хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

- ❖ Шилэн кабелиар өрхийн интернет холбосон өрхүүдийн хувьд техникийн үзүүлэлт, үнэ, хурд, чанар гэрээнд заасан үзүүлэлтээ огт хангадаггүй байна.
- ❖ Интернэтгүй иргэдийн хувьд гэртээ интернэт тавиулаагүй шалтгаан нь ерөнхийдөө 2 хэсэгт хуваагдаж байсан. Нэг хэсэг нь өмнө нь интернэттэй байж үзсэн боловч зардал өндөр, ашиггүй, хэрэггүй гэж үзсэн учраас өрхийн интернэтээс татгалзсан, нөгөө хэсэг нь анхнаасаа огт өрхийн интернэт хэрэглээгүй, гар утасны датагаар интернэтийн хэрэглээгээ хангаад, болгоод сурчихсан учраас өрхийн интернэтийн хэрэгцээ байхгүй гэж үздэг байна. Ярилцлагын явцад өрхийн интернэтгүй хэрэглэгчид гэртээ интернэт тавиулах хүсэлтэй болж буй шалтгаанаа утасны дата дангаараа интернэтийн хэрэглээг хангахад өртөг өндөр байгаагаар тайлбарлаж байлаа.
- ❖ Интернэтийн үйлчилгээний хувьд “дата, хурд, үнэ” интернэтийн чухал үзүүлэлт болохыг онцолсон. Өрхийн интернэтгүй иргэдийн хувьд гэртээ интернэт тавиулснаар интернэтийн зардал нь 50 орчим хувиар хэмнэгдэх боломжтой гэж үзэж байна.
- ❖ Өрхийн интернэтгүй хэрэглэгчдийн хувьд ойрын хугацаанд интернэт төхөөрөмж тавиулах хүсэлтэй ч хугацааны хувьд харилцан адилгүй. Учир нь 1-т хичээл сургууль амарч байгаа учраас, 2-т зуны амралтын улирал эхэлж, хөдөө гадаа явдаг зэргээс шалтгаалж интернэтийн үйлчилгээг ойрын хугацаанд тавиулах хэрэгцээ шаардлага нь багасаж байгаа, 9 сараас хичээл, сургууль эхлэх үед интернэт холбуулах хүсэлтэй гэдгээ илэрхийлсэн.

Өрхийн интернетийн сэтгэл ханамжийн хувьд:

- ❖ Гэр хорооллын юнивишн хэрэглэгчдийн хувьд хэрэглээний хугацаа нь 1-2 сар болж буй хэрэглэгчид бөгөөд үйлчилгээндээ сэтгэл ханамж өндөртэй байсан бол 1-2 жилийн хугацаанд хөдөлгөөнт интернэт болох ГЭР ИНТЕРНЭТ хэрэглэгчдийн хувьд сэтгэл ханамжийн түвшин маш доогуур байсан. Энэ нь ГЭР ИНТЕРНЭТ-ийн үйлчилгээ гэрээнд заасан хурд, чанарт хүрч чадахгүй байгааг харуулж байна. Хэрэглэгчийн хувьд ярилцлагын явцад олон гомдол, саналуудыг тоочиж байсан. Тухайлбал, гэрээний хугацаанд сар дотроо багцийн дата хэмжээний хувьд болон хурдны хувьд гацахгүй, хэрэглээг бүрэн дүүрэн хангаж байсан бол нэр дээр өөрийн нэр дээр шилжсэн үед дата хурд, хэмжээ багассан, нэмэлтээр сунгасан дата багцийн үлдэгдэлийг нь дараа сард шилжих үед буцаагаад авдаг, олон хүн орсон тохиолдолд гацдаг зэрэг шалгаануудыг тоочиж байсан. Энэ нь тоон судалгааны дүгнэлтийг илүү бататгаж байгааг харж болно.
- ❖ Дата үйлчилгээ болон өрхийн интернэтэд тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийн хувьд хотын захын гэр хорооллуудад оргил цаг буюу 19-21 цагуудад интернэтийн хурд удааширах, интернэт гацах асуудлууд гардаг бол төвийн дүүргийн гэр хорооллуудад энэхүү асуудал харьцангуй гайгүй байдаг байна.
- ❖ Дата үйлчилгээндээ сэтгэл дундуур ч үүнээсээ болж утасны оператороо солих хүсэлтэй хүн байгаагүй. Учир нь 1-т дугаараа олон жил барьсан, 2-т эргэн тойрны хүмүүс нь ижил операторынх тул сүлжээндээ үнэгүй ярьдаг, 3-т утасны дугаараа солих гэхээр улсын бүртгэлийн бүх бичиг баримт, банкны бичиг баримт, ажлын бичиг баримтууд, бусад холбоо хэрэгсэл барих бүх л баримт бичгүүд дээрх дугаараа дахин солихоор болно гэх мэт дагалдах олон асуудлуудтай тулгарах үүднээс дугаараа солих бодолгүй.
- ❖ Шилэн кабелийн дэд бүтэц тухайн амьдарч буй дүүрэгт тавигдах үед гэртээ интернэт шууд тавиулах хүсэлтэй хүмүүсийн эрэлт, шинэ төрлийн интернэтийн үйлчилгээ санал болговол гэрийнхээ интернэтийг солиулах хүсэлтэй байгаа ч интернэтийн хэрэглээ их байгааг харуулж байна. Нөгөө талаар шинэ төрлийн санал болгосон үйлчилгээ нь өмнөх интернэтийн хэрэгцээнээс ямархуу давуу талтай болоход эргэлзсэн байр суурьтай байгаа нь иргэдэд очиж буй мэдээлэл, сурталчилгаа хангалтгүй байгааг илтгэж байна.

- ❖ Юнивишн суурин интернэт хэрэглэгчдийн хувьд дата хэрэгцээндээ сэтгэл ханамжтай хэдий ч түүнийг гэрээс бусад газар ашиглах боломжгүй нь дээр таагүй сэтгэгдэлтэй байгаагаа илэрхийлж суурин интернэтийн датагаа гар утастайгаа холбох боломжтой эсэх талаар байр сууриа илэрхийлж буй нь зах зээл дээрх суурин интернэтийн багцийн үйлчилгээнүүдийг илүү сонголттой, олон төрлөөр ашиглаж болохуйц үйлчилгээнүүд нэвтрүүлэх эрэлт хэрэгцээ байгааг илэрхийлж байна.